

ГАРЧИГ

1	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл	3
1.2	Төслийн байршил	6
1.3	Тухайн жилийн уулын ажлын төлөвлөлт	8
2	ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	13
2.1	Байгаль орчны төлөв байдал	13
3	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	26
3.1	Төслийн гадаад болон дотоод овоолго барьж байгуулах үеийн гол нөлөөлөл	27
3.2	Гадаад болон дотоод овоолго байгуулснаас хойшхи үйлчилгээнээс байгаль орчинд үзүүлэх гол нөлөөлөл	27
3.3	Төслөөс агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл	28
3.4	Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл	29
3.5	Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл	29
3.6	Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл	30
3.7	Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл	30
3.8	Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл	30
3.9	Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	31
3.10	Хуримтлагдах нөлөөлөл	31
4	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	32
5	СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	32
6	НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	33
7	БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
8	НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	34
9	ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
10	ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	35
11	ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	35
12	ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	37
13	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	40
14	ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	41
15	БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ	42

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл	3
Хүснэгт № 2. MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн солбилцол	7
Хүснэгт № 3. Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын календарчилсан төлөвлөгөө	8
Хүснэгт № 4. Овоолгын төлөвлөлт	8
Хүснэгт № 5. Уулын ажлын механикжуулалтын бүтэц	9
Хүснэгт № 6. Экскаваторын бүтээлийн тооцоо	9
Хүснэгт № 7. Хөрсний дээж авсан цэгийн байршил	15
Хүснэгт № 8. Баяндун сумын бэлчээрийн ургамалжилтын шалгуур үзүүлэлт	17
Хүснэгт № 9. Баяндун сумын усны газрын тайлбар	18
Хүснэгт № 10. Сав газар дахь худгийн тоо	19
Хүснэгт № 11. Эм Би Эм Эс ХХК-ийн усны шинжилгээ	19
Хүснэгт № 12. “Эм Би Эм Эс” ХХК-ийн усны шинжилгээний стандарт үд дүнтэй харьцуулсан үзүүлэлт	19

Хүснэгт № 13. Баяндун сумын хүн амын тоо /2018-2022 он/	24
Хүснэгт № 14. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа.....	26
Хүснэгт № 15. Гол нөлөөллийн дүн шинжилгээ	26
Хүснэгт № 16. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ.....	28
Хүснэгт № 17. Автомашины утааны бүрдэл найрлага	29
Хүснэгт № 18. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл	31
Хүснэгт № 19. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	32
Хүснэгт № 20. Төслийн талбайн мониторингийн хяналт шинжилгээний цэгүүд	39

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг № 1. Төслийн талбайн байрзүйн зураг	6
Зураг № 2. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршлийн зураг	13
Зураг № 3. Төслийн талбайн хөрсний хэв шинж.....	14
Зураг № 4. Төслийн талбайн ургамалжилт.....	16
Зураг № 5. Төслийн талбайн ургамалжилтын байдал /7-р сард/	17
Зураг № 6. Ургамлын нормчилсон индекс (NDVI) 2021-2022 оны зураг	18
Зураг № 7. Дорнод аймаг Баяндун сумын усан сангийн хамгаалалтын зураг	18
Зураг № 8. Дорнод аймгийн Баяндун сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зураг	21
Зураг № 9. Хүн амын тоо, насны бүлгээр 2022 он	24
Зураг № 10. Өрхийн тоо, 2022 он.....	24
Зураг № 11. Малын төрлөөр эзлэх хувь, 2022 оны байдлаар	25
Зураг № 12. Дорнод аймгийн Баяндун сумын албан ёсны сайт болон нүүр номын харагдах байдал /2024 оны 01 сарын 09-ны өдрийн байдлаар/	25
Зураг № 13. Дорнод аймгийн Баяндун сумын засаг захирааны нэгжийн зураг	25
Зураг № 14. Хогийн савны төрөл	36
Зураг № 15. Мониторингийн цэгүүдийн зураг	40


1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Эм Би Эм Эс” ХХК-ын MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй алтны шороон ордын талбай нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн хойш 700 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос баруун хойш 240 км, Баяндун сумын төвөөс баруун хойш 30 км зайд тус тус байрлана. Талбай нь номенклатурын хувьд М-49-095 хавтгайд байрладаг. Талбайн хэмжээ нь 738.42 га.

Хүснэгт № 1. Төслийн ерөнхий мэдээлэл

Нэг. Төслийн шаардлагатай бичиг баримтын бүрдэл		
1.1	Тусгай зөвшөөрөл	“Эм Би Эм Эс” ХХК-ийн Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV- 022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлийг АМГТХЭГ-ын даргын 2023 оны 10-р сарын 16-ны өдрийн шийдвэрээр олгосон юм.
1.2	ТЭЗҮ-ийн баталсан тушаал	АМГТГ-ын даргын 2024 оны 03 сарын 14-ны өдрийн тушаал
1.3	Нөөц хүлээж авсан тушаал	Үндэсний геологийн албаны даргын 2023 оны 06 сарын 02-ны өдрийн Н-31 тоот тушаал
1.4	Нөөц хүлээж авсан дүгнэлт	Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт 2023 оны 03 сарын 02-ны өдрийн ХХ-02-01 тоот дүгнэлт
1.5	Багийн Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл	2024 оны 06 сарын 08-ны өдрийн Түргэн багийн тэмдэглэл
1.6	Багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол	2024 оны 06 сарын 08-ны өдрийн №1 Түргэн багийн тогтоол
1.7	Усны боломжит нөөцийн дүгнэлт	2024 оны 01 сарын 31-ны өдрийн №01/114 тоот усны боломжит нөөцийн дүгнэлт
1.8	Ерөнхий үнэлгээний дүгнэлт	БОАЖЯ-ны 2023 оны 08 сарын 31-ны өдрийн 2023/СН-45 тоот Ерөнхий үнэлгээний дүгнэлт
1.9	Археологийн дүгнэлт	Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбар антропологи, археологийн тэнхимийн хийсэн 2021 оны дүгнэлт
1.10	Палеонтологийн дүгнэлт	ШУА Палентлогийн хүрээлэнгийн 2021 оны 10 сарын 12-ны өдрийн №Т/91 дүгнэлт
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн нэр	Алтны шороон ордыг ил аргаар ашиглах
2.2	Төслийн байршил	Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрладаг

		 “Эм Би Эм Эс” ХХК Хонгорын алтны шороон орд Ордын байршил Таних [Зүүн талбай] Тусгай хамгаалалт [Хуучин талбай] Хуучин талбай [Алслагдсан] Алслагдсан “Эм Би Эм Эс” ХХК Хонгорын алтны шороон орд Тусгай зөвшөөрлийн талбайн план зураг
2.3	Зорилго	“Эм Би Эм Эс” ХХК нь өөрийн талбайд тогтоогдсон алтны нөөцөд тулгуурлан, ордыг Монгол Улсын хууль, холбогдох дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайн ашиглалтыг явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр оруулах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх, талбайд нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэн, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.
2.4	Төслийн ерөнхий төлөвлөгөө, ажиллах хуваарь	Уурхайн ажлын горим Уурхайн ажил улирлын чанартай буюу жил бүрийн 4-р сарын эхнээс 10-р сарыг дуустал ажиллана. Нийтдээ 6 сарын хугацаа буюу 200 хоног ажиллах боломжтой. (ТЭЗҮ 37-р хуудас) Уурхайн ажлын горимыг жилд амрах баяр ёслолын хоног, цаг агаарын хүндрэлийн хоног, мөн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хоногуудыг тус тус оруулсан байна. Уурхайн нээлт Уурхайн нээлтийг Жалга 1-ийн 1-В блокоос эхлэн нээнэ. Нээлтийн ажлаар 4.0 мян.м³ уулын ажил хийх бөгөөд 1-В блок дахь 2.8 мян.м³ хөрсийг хуулж түр гадаад овоолго үүсгэнэ, харин 1-В блокоос олборлох 1.2 мян.м³ элсийг элс угаах талбайд хураана. Уурхайн ашиглалтын төрөл Ил уурхайн хүчин чадлыг харгалзан авто-тээвэртэй гадаад, дотоод овоолготой ашиглалтын системийг сонгон авсан байна. Ажилчдын орон тоо, цалингийн зардал (сан) Алтны шороон орд ашиглах төсөл хэрэгжих хугацаанд зуны улиралд вахтын системээр 6 сар ажиллах ба уурхайд нийтдээ 78 хүн ажиллах юм. Хоногт 12 цагийн 2 ээлж ажиллах учир ажиллагсад ажлын хоног бүрд 2 цагийн илүү цагийн хөлс олгох юм. Ажиллах хугацаанд ажиллагсдын сарын дундаж цалин илүү цаг тооцсоноор 46500 мянган төгрөг болж байгаа. Нэг хүний дундаж цалин 3.3 сая төгрөг.
2.5	Хүчин чадал	Төслийн хүчин чадал, орд ашиглалтын хугацаа

<


		Уурхай ашиглалтын 1 жилийн хугацаанд нийт 120.81 тонн дизель түлш зарцуулахад хөө – 1.87 тн, CO-0.00001208 тн, нүүрстөрөгч- 3.6243 г, NO ₂ –0.00005927 тн, SO ₂ -0.00000242 тн, бензопирин- 0.000474 тн буюу нийтдээ 1.871 тн хорт хий ялгарахаар байна.
2.7	Ариун цэврийн байгууламж	Ажилчдын гэр кемп дотор төвлөрсөн ариун цэврийн байгууламжтай бөгөөд байгаль орчин, ариун цэврийн цаасыг зөв зохистой ашиглах, хувийн ариун цэвэр сахих соёлын тухай санамжуудыг байрлуулж ба экологийн боловсролын булан бий болгосон.
2.8	Усан хангамж	Тус уурхай нь өөрийн гүний худагтай.
2.9	Цахилгаан хангамж	Дизель генератор: QSY150GF 150 кВт 2ш,
2.10	Дулаан хангамж	Улирлын чанартай ажиллах тул дулаан хангамж шаардлагагүй.

1.2 ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны харьяаллаар Дорнод аймгийн Баяндун сумын нутагт багтана.

Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол Улсын зүүн хэсэгт Улаанбаатар хотоос зүүн хойш 700 км, Дорнод аймгийн төв Чойбалсан хотоос баруун хойш 240 км, Баяндун сумын төвөөс баруун хойш 30 км зайд байрлана. Талбай нь номенклатурын хувьд М-49-095 хавтгайд байрладаг.

Газрын байршил орон сууц, олон нийтийн байгууламж бүхий хэсгээс 2 км-ийн зайд байрладаг нь “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS 5105 : 2001 стандартын шаардлага хангаж байна.



Зураг № 1. Төслийн талбайн байрзүйн зураг

Хүснэгт № 2. MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн солбилцол

№	Уртлаг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	113°	26'	10.62"	49°	31'	6.55"
2	113°	23'	31.92"	49°	31'	6.55"
3	113°	23'	31.7"	49°	31'	1.91"
4	113°	23'	43.44"	49°	31'	1.67"
5	113°	23'	43.43"	49°	31'	1.6"
6	113°	23'	44.81"	49°	31'	1.57"
7	113°	23'	44.24"	49°	30'	49.9"
8	113°	24'	1.98"	49°	30'	49.54"
9	113°	24'	1.97"	49°	30'	49.47"
10	113°	24'	3.35"	49°	30'	49.45"
11	113°	24'	2.58"	49°	30'	33.56"
12	113°	24'	21.41"	49°	30'	33.17"
13	113°	24'	21.41"	49°	30'	33.11"
14	113°	24'	22.78"	49°	30'	33.08"
15	113°	24'	22.14"	49°	30'	19.75"
16	113°	24'	36.9"	49°	30'	19.45"
17	113°	24'	36.9"	49°	30'	19.39"
18	113°	24'	38.27"	49°	30'	19.36"
19	113°	24'	37.55"	49°	30'	4.88"
20	113°	24'	43.87"	49°	30'	4.74"
21	113°	24'	43.87"	49°	30'	4.68"
22	113°	24'	45.25"	49°	30'	4.65"
23	113°	24'	44.7"	49°	29'	51.4"
24	113°	24'	54.24"	49°	29'	51.21"
25	113°	24'	54.24"	49°	29'	51.14"
26	113°	24'	55.62"	49°	29'	51.11"
27	113°	24'	55.22"	49°	29'	43.05"
28	113°	25'	10.72"	49°	29'	43.05"
29	113°	25'	10.62"	49°	30'	2.11"
30	113°	26'	0.57"	49°	30'	2.11"
31	113°	26'	0.57"	49°	30'	2.01"
32	113°	26'	1.96"	49°	30'	2.01"
33	113°	26'	2.04"	49°	28'	42.05"
34	113°	26'	30.72"	49°	28'	42.05"
35	113°	26'	30.72"	49°	28'	41.95"
36	113°	27'	0.71"	49°	28'	41.95"
37	113°	27'	0.71"	49°	29'	1.96"
38	113°	26'	32.12"	49°	29'	1.96"
39	113°	26'	32.12"	49°	29'	2.05"
40	113°	26'	30.72"	49°	29'	2.05"
41	113°	26'	30.69"	49°	29'	29.12"
42	113°	26'	30.66"	49°	29'	54.05"
43	113°	26'	36.7"	49°	29'	54.05"
44	113°	26'	36.61"	49°	30'	34.01"
45	113°	26'	12.01"	49°	30'	34.01"
46	113°	26'	12.01"	49°	30'	34.11"
47	113°	26'	10.63"	49°	30'	34.11"

1.3 ТУХАЙН ЖИЛИЙН УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Ашиглалтын дараалал

Жалгуудад тогтоогдсон нөөцөөс нийт 7 жалгыг олборлохоор тооцсон ба жалга бүрд ил уурхай үүснэ. Ил уурхайн ашиглалтын 2-р улиралд Жалга-1, 3, 5, 6, 7 жалгуудыг, 3-р улиралд Жалга-8, 9 ашиглаж нийт 207.22 мян.м³ хөрс хуулалтын ажил хийж, 63.01 мян.м³ элсийг элс баяжуулах цехийн талбайд хүргэнэ.

Уурхайн бүтээгдэхүүн гаргалт

Төлөвлөгөөгөөр нийт 270.23 мян.м³ уулын цул хөдөлгөх ба үүнээс хөрс хуулалтын хэмжээ

207.22 мян.м³, элс олборлолтын хэмжээ 63.01 мян.м³ байна.

Олборлолтын явцад жалга тус бүрд блокийн нээлтийн ажил хийх бөгөөд нээлтийн үед хуулсан хөрсийг гадаад түр овоолгод байршуулж, олборлосон элсийг элс угаах талбайд тээвэрлэн хүргэнэ.

Харин тухайн нээсэн блокийн элсийг бүрэн олборлож, хоосон орон зай үүсэх үед залгаа блокуудын хөрсийг шууд дотоод овоолго байгуулах замаар нөхөн дүүргэлтийг хийж явна.

Хүснэгт № 3. Уурхайн бүтээгдэхүүн гаргалтын календарчилсан төлөвлөгөө

Үзүүлэлт	Нэгж	II, Шулирал
Элс олборлолт	мян.м3	63.01
Дундаж агуулга	мг/м3	373
Алтны хэмжээ /х.ц/	кг	23.54
Хөрс хуулалт	мян.м3	207.23
Хаягдлын сан байгуулах уулын ажлын хэмжээ	мян.м3	25.0
Ил уурхайн хөрс хуулалтын дундаж коэффициент	м3/м3	3.40
Нийт олборлох элсний хэмжээ	мян.м3	63.01
Олборлох элсэн дэх алтны дундаж агуулга	мг/м3	373
Бохирдлын хувь	%	30.67
Бохирдлын хэмжээ	мян.м3	14.79
Нийт уулын цулын хэмжээ	мян.м3	270.23
Үйлдвэрлэлийн нөөц дэх элсний хэмжээ	мян.м3	63.01
Үйлдвэрлэлийн нөөцийн элсэн дэх алтны дундаж агуулга	мг/м3	373
Үйлдвэрлэлийн нөөцийн элсэн дэх алтны хэмжээ /Х.ц/	кг	23.54

Овоолгын төлөвлөлт

Ордын тогтцоос хамаарч ил уурхай тус бүр хөрсний түр гадаад овоолго, шууд байрших хөрсний дотоод овоолго болон нөхөн дүүргэлттэй байна. Овоолгын төлөвлөлтийг улирал тус бүрээр тооцож гаргасан бөгөөд шууд байрших дотоод овоолгын хэмжээ 2.8 мян.м³,

159.7 мян.м³, 53.4 мян.м³, түр гадаад овоолгын хэмжээ 2.8 мян.м³ байна.

Хүснэгт № 4. Овоолгын төлөвлөлт

Үзүүлэлт	Нэгж	2-р улирал
Хуулах хөрс	мян.м ³	192.0
Сийрэгжилт	-	1.30
Хөрсний сийрэгжсэн эзлэхүүн	мян.м ³	249.6
Дотоод овоолгын эзлэхүүн	мян.м ³	2.8
Гадаад овоолгын эзлэхүүн	мян.м ³	246.8
Нөхөн дүүргэлт буюу нөхөн сэргээлтэд ашиглах хөрсний хэмжээ	мян.м ³	2.8

Ил уурхайн процесс

Ил уурхайн процесс нь хөрс хуулалт, элс олборлолт, овоолго байгуулах болон туслах ажлуудыг иж бүрнээр нь аюул осолгүй, эдийн засгийн үр ашигтай явуулах, зорилтод бүтээмжийг хангах ёстой. Ордын ашиглалтын үед дараах процессууд явагдана. Үүнд:

- Үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил
- Хөрс хуулалтын ажил
- Элс олборлолтын ажил
- Элс угаалтын (баяжуулалтын) ажил
- Хөрсний дотоод овоолго, тэгшлэлтийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил

Хүснэгт № 5. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Шимт хөрс хуулалт
		Ухаж ачих
		Тээвэрлэх Овоолох
	Олборлолт	Ухаж ачих
		Тээвэрлэх
		Агуулахад хураах

Шимт хөрс хуулалт

2025 оны ил уурхайн ашиглалтаар нийт 6.4 га талбай эвдэгдэж үүнээс Жалга 1, 3 буюу 1, 2-р ил уурхайн ашиглалтаар эвдэгдэх 3.6 талбайн шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолго-1 ийг, Жалга 5, 6 буюу 3, 4-р ил уурхайн ашиглалтаар эвдэгдэх 1.5 талбайн шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолго-2 ийг, Жалга 7, 8 буюу 5, 7-р ил уурхайн ашиглалтаар эвдэгдэх 1.3 талбайн шимт хөрсийг хуулж шимт хөрсний овоолго-3 ийг тус тус байгуулахаар төлөвлөлөө.

Ухаж ачих процесс

Экскаваторын бүтээлийн тооцоог дараах хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт № 6. Экскаваторын бүтээлийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	Нэгж	Ашиглалтын жил
			2025 он
Тооцооны үзүүлэлт			
1	Экскаваторын утгуурын багтаамж, Е	м ³	3.1
2	Чулуулгийн эзлэхүүн жин	тн/м ³	1.80
3	Утгуур дүүргэлтийн коэффициент	-	0.9
4	Мөргөцгийн нөхцөл тооцох коэффициент	-	0.9
5	Экскаваторын төрлийг тооцох коэффициент	-	1.1
6	Утгуур дахь чулуулгийн сийрэгжилтийн коэффициент	-	1.3
7	Экскаваторын мөчлөгийн хугацаа	сек	28
Бүтээлийн тооцоо			
8	Экскаваторын цагийн бүтээл	м ³ /цаг	273.2
		тн/цаг	491.7
9	Ээлжийн цаг ашиглалтын коэффициент	-	0.86
10	Мөргөц дэх ахилт шилжилт тооцох коэффициент	-	0.9
11	Экскаваторын төрлийг тооцох коэффициент	-	1.1
12	Экскаваторын ээлжийн бүтээл	м ³ /ээлж	2,825.6
		тн/ээлж	5,086.1

14	Экскаваторын хоногийн бүтээл	м ³ /хон	5,651.3
		тн/хон	10,172.3
15	Техникийн бэлэн байдлыг тооцох коэффициент	-	0.7
16	Экскаваторын жилийн бүтээл	мян.м ³ /жил	791.2
		мян.тн/жил	1,424.1
17	Уурхайн жилд гүйцэтгэх ажлын хэмжээ	мян.м ³ /жил	487.4
18	Экскаваторын тооцооны тоо	шир	0.6
19	Нийт экскаваторын жилд ажиллах цаг	мото.цаг	2,546
20	Шаардлагатай экскаваторын тоо	шир	1.0

Экскаваторын жилд хийх уулын ажлын хэмжээг тооцоход нийт хөрс хуулалт, шимт хөрс хуулалт, элс олборлолтын ажил дээр, нуур далан байгуулах ажлын хэмжээг нэмж тусган тооцлоо. Тооцоогоор уурхайн хөрс хуулалт болон элс олборлолтод XCMG-XE490DK маркийн экскаватор 1 ш байхад уурхайн хүчин чадлыг бүрэн хангаж ажиллахаар байна.

Тээвэрлэх процесс

Дотоод тээвэрт XCMG-XE490DK маркийн экскаватортой хосолж HOWO-290 маркийн автосамосвал ажиллана. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөөний дагуу жилд 207 мян.м³ хөрс хуулж, 63,01 мян.м³ элс олборлоно. Хуулсан хөрсийг хөрсний гадаад болон дотоод овоолгод, шимт хөрсийг шимт хөрсний овоолгод, харин олборлосон элсийг уурхайн мөргөцгөөс экскаватор-автосамосвалын хослолоор ачиж элс угаан баяжуулах хэсгийн дэргэдэх элсний түр овоолго руу тээвэрлэнэ.

Тооцоогоор автосамосвалын тээврийн дундаж зай 1,056 м, нийт тээвэрлэх уулын цулын хэмжээ 270.23 мян.м³ байна.

Автосамосвалын хоосон чиглэл дэх хурдыг 25 км/цаг, ачаатай чиглэл дэх хурдыг 15 км/цаг байхаар тооцож тээврийн хугацааг тодорхойлсон.

Тооцоогоор уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын ажилд HOWO 290 маркийн автосамосвал 4 ширхэг байхад уурхайн хүчин чадлыг бүрэн хангаж ажиллахаар байна.

Овоолгын ажил

Хөрсний овоолго: Хөрсний овоолгод автосамосвалаар ачаа асгах үед ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу хөмсөг болон далангийн өндөр уурхайн технологийн автосамосвалын хамгийн том өөрөө буулгагч автосамосвалын дугуйны диаметрийн ½ (Хоёрны нэг)-с багагүй өндөртэй байна.

Хөрсний овоолгод ашиглалтын хугацаанд сийрэгжсэн эзлэхүүнээр нийт 270.23 мян.м³ хөрс хураагдана.

Шимт хөрсний овоолго: Шимт хөрсийг бульдозероор хуулан овоолж, экскаватор автосамосвалын хослолоор ачиж тээвэрлэн төлөвлөсөн шимт хөрсний овоолгод хураана. Шимт хөрсний овоолгыг 2 м өндөртэй хураахаар төлөвлөлөө. Шимт хөрсний овоолго дээгүүр хүнд даацын машин явж нягтаршуулахгүй овоолно.

Шимт хөрсний овоолгод ашиглалтын хугацаанд сийрэгжсэн эзлэхүүнээр нийт 82.8 мян.м³ шимт хөрс хураагдана.

Бульдозерын жилд хийх ажлын хэмжээ нь автосамосвал асгалт хийсний дараах үлдсэн хөрсийг түрж тэгшлэх зэрэг ажлууд байх бөгөөд нийт хөрсний 30% байхаар тооцсон байна.

Тооцоогоор XCMG Ty230 маркийн бульдозер 1 ширхэг байхад уурхайн хүчин

чадлыг бүрэн хангаж байна.

Элс баяжуулах цехийн элс ачилт

Тээвэрлэгдэн ирсэн элсийг бөөгнүүлэх, угаах төхөөрөмжийг тэжээх, угаагдсан эфель, гаалийг хуучин уурхайн ухааш дотор тараан түрэх, уурхайн зарим туслах ажлуудад XCMG LW550FN маркийн 3.0 м³ утгуурын багтаамжтай утгуурт ачигч ажиллана.

Дээрх тооцооноос харахад тээвэрлэгдэн ирсэн элсийг бөөгнүүлэх, скрубберийг элсээр тэжээх, эфель гаалийг зайлуулах зэрэг ажлуудад XCMG LW550FN маркийн утгуурт ачигч 1 ширхэг байхад хүчин чадал нь хангалттай хүрэлцэж байна.

Баяжуулалтын технологи:

Баяжуулах технологийн горим

Баяжуулах цех нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байхаас гадна, хаягдалд металл алдахаас сэргийлэх үүднээс технологийн урсгалыг турбулент урсгал үүсэхээр тохируулж металл суух хугацааг бүрдүүлэх байдлаар тоног төхөөрөмжийг суурилуулна.

Ил уурхайгаас олборлосон элсийг автосамосвалаар тээвэрлэн баяжуулах цехийн тэжээлийн талбайд буулгана. Тэжээлийн талбай дахь алт агуулсан элсийг утгуурт ачигчаар скрубберийн бункерт ачаална. Суурин байрлах Скрубберт угаан ангилах төхөөрөмж нь элсийг 20 мм-ийн хүрдэн шүүрээр шигшиж, угаан ангилна. Хүрдэн шүүрний дээд ангилал буюу хоосон чулуулаг галийн овоолго руу хаягдана.

Угаан ангилах төхөөрөмжийн хүрдэн шүүрийн доод ангиллын бүтээгдэхүүн шлюзэд орно. Шлюзны хаягдал нь өөрийн урсгалаар хаягдлын сан руу орно. Шлюзны баяжмалыг ээлжиндээ 1-2 удаа /4-8 цаг тутамд/ авна. Цуглуулсан баяжмалыг шигшүүрээр /-20+2 мм ба

-2+0 мм/ 2 фракцад ялгана. -20+2 мм ширхэглэлийн ангиллыг сайтар шалгасны дараа хаях ба -2+0 мм ангиллыг сэгсрэх ширээ баяжуулна. Сэгсрэх ширээнээс шлихийн алт, хаягдал гэсэн 2 бүтээгдэхүүн гарна.

Хатуу шингэний харьцаа нь 1:4-6 байхаар, урсгалын хурдыг 1.7-2 м/сек байхаар тохируулж хуулсны дараа трафератыг коврик резин дээр жигд суулгаж өгөх, шлюзийн налууг тохируулах зэрэг технологийн горимыг нарийн чанд барьж ажиллана.

Баяжмал цэвэршүүлэх ерөнхий зарчим нь баяжуулах ширээнээс гарсан шлихийн алтыг хатааж соронзон ялгагчаар металл үртсийг ялгаад шигшинэ.

Баяжуулах цехийн ажиллах горим

Элс угаан баяжуулах технологийн тооцоогоор технологийн оновчтой горим, тоног төхөөрөмжийн хүчин чадал, тэдгээрийн сонголт, технологид зарцуулагдах усны хэмжээ, бүтээгдэхүүн гаргалтыг тооцоолов. Элс угаан баяжуулах цех нь ил уурхайн төлөвлөгөөний дагуу олборлосон элсийг дулааны улиралд 4-р сарын дундаас 10 сарыг дуустал угаах үйл ажиллагаа явуулахаар төлөвлөв.

Төсөлд “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн хоёрдугаар бүлгийн 4 дүгээр зүйлийг үндэслэн төлөвлөгөөт ажлын хугацаанд “Нийтээр тэмдэглэх баярын өдөр”-ийг 7 өдрөөр, цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдлыг 7 өдрөөр, төлөвлөгөөт засвар үйлчилгээг 6 өдрөөр тооцож сардаа 25 өдөр ажиллаж байхаар төлөвлөв. Уурхайн төлөвлөлтийн дагуу сийрэгжилт тооцсоноор төслийн хугацаанд нийт

135.6 мян.м³ сийрэгжсэн элс угаана.


Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Элс угаан баяжуулах цех нь элсийг гравитацийн аргаар баяжуулж шлихийн алтыг
үйлдвэрлэнэ. Алтны шороон ордын сорьц 875 байгаа бөгөөд төслийн нийт хугацаанд
химийн цэврээр 23.54 кг алт үйлдвэрлэнэ.

2 ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Төслийн талбай орчимд хуулиар хамгаалагдсан газар нутаг, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байхгүй байна. Харин төслийн үйл ажиллагааны үр дүнд газар нутгийн эмзэг байдлаас шалтгаалж сөрөг нөлөө үүсэх, үүссэн сөрөг нөлөө хуримтлагдаж болзошгүй нөхцлүүд байх боломжтой байна.



Зураг № 2. Төслийн талбайн районы д.т.д үнэмлэхүй өндөршилтийн зураг

Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Ордод 7 жалгад нөөц тооцогдсон ба жалга бүрд ил уурхай үүснэ. Нээлтийн ажлыг жалга-1 буюу 1-р ил уурхайгаас эхлэн ашиглаж эхлэнэ. Ил уурхайн ашиглалтын 2-р улиралд Жалга- 1, 3, 5, 6, 7-р жалгуудыг ашиглаж нийт 139.8 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, 53.3 мян.м3 элсийг элс баяжуулах цехийн талбайд хүргэнэ.

Ил уурхайн ашиглалтын 3-р улиралд Жалга-9 –ийг ашиглаж нийт 157.3 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, 53.4 мян.м3 элсийг элс баяжуулах цехийн талбайд хүргэнэ.

Ил уурхайн ашиглалтын 4-р улиралд Жалга-8 –ийг ашиглаж нийт 52.2 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, 6.3 мян.м3 элсийг элс баяжуулах цехийн талбайд хүргэнэ.

Агаарын чанар

Баяндун сумын уур амьсгалын олон жилийн дундаж үзүүлэлтийг Монгол улсын “Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн” Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу Баяндун цаг уурын харуулын (ДТД-947 м) 1991-2020 оны агаарын температур, хур тунадасны стандарт нормыг цаг хугацааны сарын алхамтай тооцоолсон мэдээг ашиглав.

Судалгааны талбай орчмын газар нутаг нь ерөнхийдөө дулаан уур амьсгалтай, хур чийг багатай. Өвлийн улиралд гэнэтийн дулааралт бараг ажиглагддаггүй бол зуны улиралд гэнэтийн хүйтрэлт хааяа тохиолдоно. Агаарын температурын бас нэг онцлог бол хавар, намрын улирал богинохон, халуун хүйтний солилцоо эрс байдаг явдал юм.

Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 161.6-555.1 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд 1.5-3.1 мм, хаврын улиралд 2.7...37.4 мм, зуны улиралд

лабораторийн задлан шинжилгээ зориулж үе давхарга тус бүрээс дээж авдаг. Судалгааны талбайд хөрсний зүсэлт гүйцэтгэх, дээж авалт, тээвэрлэлт хадгалалтыг гүйцэтгэхдээ Монгол улсын стандарт “MNS3298-90: Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд”, МУ-ын стандарт MNS2305-94: Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх журам” зэрэг холбогдох журам, стандартанд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Хөрсний зонхилох тархсан хэв шинжийг илрүүлэх зорилгын хүрээнд төслийн талбайн хүрээнд урьдчилсан агаар, сансрын зураглалын судалгаа гүйцэтгэн, судалгааны талбайн хэмжээнд газар ашиглалт, зонхилох хөрсний тархалтыг хил заагийг ялган тодорхойлж, тухайн хөрсний хэв шинжийн тархалтын цэгийн хамгийн боломжит цэгээс хөрсний гар өрөм болон шугам ашиглан, 0-20 см гүнтэй өнгөн хөрсний 300гр дээж цуглуулсан. Лабораторийн задлан шинжилгээнд зориулсан дээжний байршлыг газар ашиглалт, зонхилох хөрсний тархалт, хөрсний эвдрэлийн байдлуудыг харгалзан сонгосон.

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрлах Халчиг Өндөр уулын хаяа уулсын системд байрлах “Эм Би Эм Эс” ХХК-ийн XV-21786 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайгуулын талбай нь хөрсгазарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн өндрийн бүсшилийн хэв шинж бүхий Хэнтийн мужийн Хэнтийн зүүн 40-р тойрогт багтана (Үндэсний атлас, 2022). Тус тойрогт өндрийн бүсшилийн дагуу ар хажуудаа ой бүхий дундаж өндөр уулсаар ойн ширэгт бараан хөрс тархах бол ойн бүстэй хил залган уулын нугын бараан хөрс, уулын нугат хээрийн харшороон хөрс дараалж тархах ба уулын ам хөндий, уул хоорондын тэгш талархаг газруудаар ам хөндийн харшороон болон нугархаг хархүрэн хөрсний хэв шинж гадаргын хэлбэр дүрстэй уялдан тархана.

“Эм Би Эм Эс ХХК”-ийн хайгуулын талбайн хөрсний хүнд элементийн агууламж Cd-ийн агууламж илрээгүй буюу багажны мэдрэгч чанарт бүртгэгдээгүй байна, төслийн талбайд Pb 19-25мг/кг, Cr 21-28мг/кг, Zn 56- 59мг/кг, Cu 22-24мг/кг, Ni 10-21мг/кг тус тус утгатай байгаа бөгөөд MNS5850:2019 стандартанд заасан хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу бохирдол үүсээгүй байна.

Төслийн нөлөөлөлд өртөх судалгааны талбайгаас цуглуулсан хөрсний дээжнүүдэд хөрсний үржил шимийн (ялзмаг, рН, Са+Мg, K₂O, P₂O₅) үзүүлэлт, өргөн тархалттай хүнд металл (As, Cd Cr, Pb) зэрэг үзүүлэлтүүдийг магадлан итгэмжлэгдсэн “Нарт ШҮҮН консалтинг” ХХК-ийн лабораторид ICP40B аргазүйгээр Optical Spectrometer (OS)-ийн багажаар тодорхойлсон.

Хүснэгт № 7. Хөрсний дээж авсан цэгийн байршил

Хөрсний дээж					
Байршил	Зүсэлт	Гүн см	Хөрсний хэв шинж	Координат	
Уулын хажуу	Зүсэлт-1	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 24' 15.110"E	49° 31' 0.305" N
Ам хөндий	Зүсэлт-2	0-20	Карбонатгүй харшороон	113° 26' 7.362" E	49° 30' 48.018" N
Хамрын орой	Зүсэлт-3	0-20	Уулын хээрийн нимгэн хархүрэн	113° 24' 45.635"E	49° 30' 18.563" N
Талхлагдсан хөндий	Зүсэлт-4	0-20	Талхагалд өртсөн хөрс	113° 26' 31.808"E	49° 30' 20.297" N
Толгодын хажуу	Зүсэлт-5	0-20	Карбонатгүй хар шороон	113° 26' 13.135"E	49° 29' 12.355" N
Толгодын хажуу	Зүсэлт-6	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 26' 59.647"E	49° 28' 56.466" N
Уулын хажуу	Зүсэлт-7	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 26' 15.151"E	49° 29' 40.906" N
Ам хөндий	Зүсэлт-8	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 24' 28.541"E	49° 30' 38.624" N
Ам хөндий	Зүсэлт-9	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 25' 8.900" E	49° 30' 8.014" N
Уулын хажуу	Зүсэлт-10	0-20	Уулын хээрийн нимгэн хархүрэн	113° 25' 2.927" E	49° 30' 47.270" N
Ам хөндий	Зүсэлт-11	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 25' 47.053"E	49° 30' 17.994" N

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрлах “Эм Би Эм Эс ” ХХК-ийн MV-022679 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Халчир Өндөр уулын системд, уулын

3. Ургамлан нөмрөгийн тусгаг бүрхэцийг Л.Г.Раменскийн аргаар тус тус тодорхойлсон.

Ургамалжлын бичиглэл: Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дахь “Эм Би Эм Эс” ХХКийн XV-021786 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрын 744.673 га талбайд 6 бичиглэл хийхэд үндсэн бүлгэмдэл нь Хиаг-хялгана-агьт, Хялгана-хиагт, Хялгана- хиаг-агьт, харгана-үетэнт, Хялгана-алаг өвс-агьт, Хиаг-дэрст, Хялгана-алаг өвст төрөл байна. Тус талбай нь хээрийн цэвэр өвслөг ургамалтай байх бөгөөд ургамлан нөмрөгийн 100 м² талбайд 17-31 зүйл, 1м² талбайд 4-8 зүйл бүртгэж, ургамалжлын хувьд ургамлын бүрхэц 53.8-64.4%, га – ийн ургац 2.372-4.77 цн байна.


Хүснэгт № 8. Баяндун сумын бэлчээрийн ургамалжилтын шалгуур үзүүлэлт

№	Бэлчээрийн төрөл	Бэлчээрийн ургамалжлын шалгуур үзүүлэлт							
		Зүйлийн тоо (100м ² талбайд)	Зүйлийн тоо (1м ² талбайд)	Ургамлын бүрхэц, %	Олирогч ургамлын бүрхэц, %	Халцгай газар, %	Хад хайрга чулуу, %	Хад, %	Ургац, ц/га
1	Хиаг-хялгана-агьт (105а /Х-I-2-4)	25	6-8	55.4	14.6	44.0	1.6	-	2.372
2	Хялгана-хиагт (105/ Х-I-2-4)	17	4-6	60.4	7.8	27.6	-	12.0	3.57
3	Хялгана-хиаг-агьт, харганаүетэнт (38-47а /У-IV-2-7 У-IV-3-1)	31	4-5	53.8	26.6	38.4	3.4	3.8	3.63
4	Хялгана-алаг өвс-агьт (110а /Х-I-2-9)	16	4-5	56.6	5.0	39.6	-	3.8	2.736
5	Хиаг-дэрст (101/ Х-I-1-4)	15	4-6	64.4	7.2	28.4	-	7.8	4.77
6	Хялгана-алаг өвст (110 /Х-I-2-9)	19	4-8	59.4	7.0	35.4	-	5.2	3.006



Зураг № 5. Төслийн талбайн ургамалжилтын байдал /7-р сард/


Ургамлын нормчлогдсон индекс /NDVI/. Ургамлын индексийн дундаж утгыг жил тус бүрээр харьцуулахад 2021 онд хамгийн их 1-0.65, 2022 онд хамгийн бага 0.33-0.66 хооронд өөрчлөгдсөн байна. Төслийн талбай нь районы хэмжээнд зуншлага сайтай жилүүдэд 1 хүрч гантай жилүүдэд 0.6 хүртэл буурдаг байна.



Зураг № 6. Ургамлын нормчилсон индекс (NDVI) 2021-2022 оны зураг

Усан орчин

Улз голд дэлхийн нүүдлийн шувууд ихээр цугладаг газруудын нэг бөгөөд ОХУ болон БНХАУ-ын нутгийг дамжин үргэлжилдэг. Улз голын сав газрын 37,280 км² талбайд жилд 464 сая м³ хэмжээтэй газрын доорх усыг ашиглах боломжтой. Улз гол түүний цутгал Бүс, Баян гол, Түргэн, Унагай, Билүүт, Урт голууд, Түргэн цагаан, Онхоодой нууртай буюу эдгээр нь номхон далайн ай савд багтдаг.



Зураг № 7. Дорнод аймаг Баяндун сумын усан сангийн хамгаалалтын зураг

Хүснэгт № 9. Баяндун сумын усны газрын тайлбар

№	Рашааны нэр, орших газар	Үе шат	Ашиглалтын байдал	Тайлбар
1	Лүнгийн рашаан (Баян дун сум)	Устай	Эмчилгээнд	Дулааны улиралд ашигладаг
2	Бүдүүний рашаан (Баян дун сум)	Устай	Эмчилгээнд	Дулааны улиралд ашигладаг

3	Эмгийн рашаан (Баян дун сум)	Устай	Эмчилгээнд	Дулааны улиралд ашигладаг
4	Могойтын рашаан (Баян дун сум)	Устай	Эмчилгээнд	Дулааны улиралд ашигладаг

Газар доорх ус нь ус үл нэвтрэх давхарга дээр оршдог бөгөөд хур борооны усаар тэжээгдэнэ. Нутгийн хойд хэсгээр дунд төрмөлийн бялхмал чулуулаг, анх төрмөлийн ба доод эрт төрмөлийн хувирмал чулуулаг, эрт төрмөлийн тунамал чулуулаг төв болон өмнөд хэсгээр палеогены ба неогены хурдас, гүний шургамал чулуулаг, дээд анх төрмөлийн ба эрт төрмөлийн бялхмал чулуулаг тархана.

Хүснэгт № 10. Сав газар дахь худгийн тоо

№	Сумын нэр	Худгийн тоо			Үүнээс	
		Инежерийн	Энгийн	Нийт	Ашиглагдаггүй	Бэлчээрийн
1	Дорнод аймаг Баяндун сум	22	80	102	11	-

Хүснэгт № 11. Эм Би Эм Эс ХХК-ийн усны шинжилгээ

Шинжилгээний тодорхойлолт	Дээжний дугаар	Дээжний хаяг байршил	Уст цэгийн төрөл
Цэвэр усны хими	№567	Дорнод аймаг, Баяндун сум, Хонхор	Гүний худаг

Хүснэгт № 12. “Эм Би Эм Эс” ХХК-ийн усны шинжилгээний стандарт үд дүнтэй харьцуулсан үзүүлэлт

№	Үзүүлэлт	Шинжлэх аргын стандарт	Зөвшөөрөгдөх хэмжээ	Үр дүн
1	рН усны орчин	MNS ISO 10523-2001	6.5-8.5	6.96
2	Цахилгаан дамжуулах чанар	MNS ISO 7888:1999	<1.0	0.44
3	Ерөнхий хатуулаг	MNS ISO 6059:2005	<7.0	3.92
4	Кальци Са	MNS 1097:1970	<100.0	60.52
5	Магни (Mg ²⁺)мг/л	MNS 1097:1970	<30.0	10.90
6	Карбонат (CO ₃) мг/л	MNS ISO 9963-1:2005	-	0.00
7	Хлорид (Cl ⁻) мг/л	MNS ISO 9297:2005	<350.0	12.05
8	Гидрокарбонат(HCO ₃) мг/л	MNS ISO 9963-1:2005	-	268.40
9	Нитрит (NO ₂) мг/л	MNS ISO 4431:2005	<1.0	0.00
10	Нитрат (NO ₃)мг/л	MNS ISO 7890-3:2001	<50.0	6.51
11	Төмөр (Fe ³⁺)мг/л	MNS ISO4430:2005	<0.3	0.00
12	Сульфат (SO ₄ ²⁻) мг/л	MNS ISO 6271:2011	<500.0	8.57
13	Хуурай үлдэгдэл мг/л, (TDS, mg/L)	MNS ISO 4423:1997	<1000.0	291.00
14	Натри+ Кали (Na ⁺ , K ⁺)	MNS ISO 1097:1970	<200.0	25.42
15	Аммони (NH ₄ ⁺)мг/л	MNS ISO 1097:1970	<1.5	0.09

“Эм Би Эм Эс” ХХК нь өөрийн эзэмшлийн худагтай. “Монгол-Ус” ТӨҮГ-ийн итгэмжлэгдсэн лабораторт усны шинжилгээ хийлгүүлж үр дүнг стандарттай харьцуулсан. Стандараас харьцад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрээгүй байна.

Амьтны аймаг

Төслийн талбайн район монгол орны Хөхтөн амьтдын тархцын газарзүйн мужийн 3-р муж буюу Баруун хянганы тойрогт хамаарагдана.

Тус газар нь Дагуурын уулын хээрийн нөлөө бүхий баруун, баруун хойд хэсгээр арай чийглэгдүү болж тэнд нугат хээрийн ургамал тархах нөхцөл бүрджээ.

Амьтан, ургамлын аймагт биогазарзүйн тойргийн нөлөө бага боловч илэрдэг бөгөөд Монголд ховор амьтан, ургамлын зүйл, тухайлбал идлэг шонхор, Дагуурын ятуу зэрэг шувууд болон дагуурын зараа байдаг.

Тус бүс нутаг нь цагаан зээрийн амьдрах орчныг бүрдүүлж, жилийн дөрвөн улиралд идээшлэх, төллөх, бэлчээрлэх томоохон байршил нутаг юм.

Завсрын байрлалд шилжилтийн өвөрмөц экосистемийг бүрдүүлдэг. Тус газар нь Дагуурын уулын хээрийн нөлөө бүхий баруун, баруун хойд хэсгээр арай чийглэгдүү болж тэнд нугат хээрийн ургамал тархах нөхцөл бүрджээ.

Төсөл хэрэгжих газар нь багавтар талбайг эзлэх бөгөөд амьтны зүйлийн бүрдлээс хамгийн их тохиолддог нь цагаан зээр, байхаас гадна чоно, үнэг, хярс, тарвага, дагуурын зурам зэрэг амьтад юм. Намар, өвлийн эхэн саруудад цагаан зээрийн нүүдлийн болон үржил явагддаг бөгөөд олон мянгаар сүрэглэсэн сүргүүд нүүдэллэн ирдэг. Энэ бүс нутагт чоно элбэг бөгөөд мөн үнэг, хярс, мануул, доргыг ч харж болно. Энд жижиг хөхтөн амьтад мөн элбэг бөгөөд махчдаас өмхий хүрэн, үен, мэрэгчдээс үлийн цагаан оготно зэрэг гол төлөөлөгчдийг нэрлэж болно.

Мөн тухайн бүс нутагт Монгол орны дорнод хэсгийн усны болон нүүдлийн зуу гаруй зүйл шувууд хуран цуглардаг. Тас шувууг тус хэсэгт харж болох нэг гол зүйл юм. Уг шувууны өндөглөх газар ба үржлийн талаар одоогоор тодорхой мэдээлэл олж чадаагүй, зүйлийг олж нотлоогүй байгаа.

Нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал

- Оршин суугчид нөлөөллийн бүсийн дотор талд хаваржаа, өвөлжөө байрлахгүй учир газар ашиглалтын эрх зөрчигдөхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр ажлын байр бий болж, нутгийн иргэд ажилд орно.
- Хамгийн ойрын суурин нөлөөллийн бүсд байрлах тул сөрөг нөлөөлөлд өртөнө.

Уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ ордын ашиглалтын хугацаан дахь эдийн засгийн үзүүлэлтүүдийг дурдвал нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 3.9 тэрбум.төг, нийт зардлын хэмжээ 5.3 тэрбум төгрөг, нийт борлуулалтын орлого 9.7 тэрбум.төгрөг, төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ $NPV/10\% = 3.0$ тэрбум.төг, хөрөнгө оруулалтын дотоод өгөөжийн норм $IRR = 93\%$, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 5 сар тус тус байна.

Төсөл хэрэгжих 1 жилийн хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1656.5 сая төгрөг оруулж байна.

Түүх соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутаг

Палеонтологи хайгуул, судалгааны ажлын дүгнэлт. Тус ордын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд палеонтологийн судалгааг ШУА-ийн палеонтологи, геологийн хүрээлэнгийн баг хамт олноор 2021 оны 09 дүгээр сарын 30-аас 2021 оны 10-р сарын 03-ны хооронд хээрийн судалгааг хийж гүйцэтгүүлсэн. Тус ажлыг явуулахдаа Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8 дугаарт заасны дагуу ажилласан байна.

Судалгааны талбайн хэмжээнд протерозойн цаг үеийн метаморф /хувирмал/ чулуулаг тархсан ба эртний амьтан ургамлын үлдвэр илрээгүй байна.

Цаашид тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд ашиглалт явуулах үе шатанд палеонтологийн сонирхолтой үнэт ховор олдвор илэрсэн тохиолдолд олборлолтын ажлыг түр зогсоож холбогдох байгууллагуудад хандан авран хамгаалах малтлага хийлгэх хэрэгтэй гэж үзсэн байна.


Түүх-Археологийн авран хамгаалах судалгааны ажлын дүгнэлт. Тус ордын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27.8, 27.9, болон Соёлын өвийн судалгаа хийх журмын 2 дугаар бүлгийн 2.1.2 болон 3.1 зэрэг заалтуудыг баримтлан тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд тархсан эртний булш болон эртний түүх соёлын хөшөө дурсгалуудыг тогтоолгох зорилгоор Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны сургуулийн Археологийн судалганы археологийн судалгааг гүйцэтгүүлсэн.

Тус компанийн Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших “Хонхор” тусгай зөвшөөрлийн талбайд археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг тус сургуулийн хээрийн шинжилгээний баг амжилттай хийж гүйцэтгэлээ. Тус хайгуулын талбай нь Баяндун сумын төвөөс чанх хойд зүгт 40 гаруй км зайд оршино. Хайгуулын талбайн намхан аараг толгодтой хайгуулын талбайн хоёр талаар ашиглалт хийж байгаа уурхай ажиллаж байна. Тусгай зөвшөөрлийн талбайд археологийн авран хамгаалах хайгуул

судалгааны ажлыг хийж гүйцэтгэх явцад ямар нэгэн археологийн дурсгал болон дурсгалт газар илэрсэнгүй.

Тусгай хамгаалалттай газар нутаг

ТХГН-ийн хувьд: Дорнод аймгийн Баяндун сумын нутагт хэрэгжих тус ордын талбайн хувьд Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг хамаарагдахгүй байна.



Зураг № 8. Дорнод аймгийн Баяндун сумын тусгай хамгаалалттай газар нутгийн зураг

Төслийн талбайтай Угтам уул Байгалийн нөөц газар ойр оршиж байна. Дорнод аймгийн Баяндун сумын төвөөс зүүн тийш 30-аад километр зайд далайн төвшнөөс дээш 1210 метр орших өндөр уул юм. Монголын Улаан номонд орсон бөгөөд Монгол Дагуурын дархан газарт тархсан нэн ховор амьтан ургамалтай. Баяндун, Дашбалбар сумын хээр талд орших ой модтой энэ уул нь Улз голын урд хэсгээр баруун өмнөөс зүүн хойшоо сунаж тогтсон. 1993 онд УИХ-ын 83 дугаар тогтоолоор тусгай хамгаалалтанд авсан. Баруунаас зүүн тийш явах тутам газрын өндөршил аажмаар намсч гадаргын байдал ухаа толгодын шинжтэй болж тал газартай нийлнэ. Монголын нилээд хойгуур өргөрөгт оршдог учраас усны баялаг харьцангуй нягт зэргээс шалтгаалан олон ам, хөндий, гуу жалгаар зүсэгдсэн хэрчигдэл ихтэй. Хар шороон хөрс, хар хүрэн нүүрс тархаж, уул толгодын бэлийн төгсгөлд, ам хөндийн ёроолд нугын ба нугат намгийн хөрс голчлон дайралдана. Баруун, Зүүн Сүүж, Аргалант, Жимгэр, Дангай, Дэл, Тавнан гэх мэтийн жижиг горхи бүхий олон хөндийтэй. Толь нуур, Хайрханы цагаан нуур, Өвгөдийн хар, Цагаан нуур зэрэг жижиг нуур тойром ихтэй. Угтамын хийдийн дэргэд Могойтын рашаан байдаг. Хамгийн том гол нь Улз гол бөгөөд Хэнтий аймгийн Норовлин сумын нутгаас эх авч Монгол дагуурын нутгаар урсан улсын хил дайран Тарь нуурт цутгана.

Ойн бүс тун бага бөгөөд хуурай хээр болон уулын хээрийн ургамал зонхилсон байдаг. Амьтны аймгаар харьцангуй баялаг бөгөөд тал газрын ихэнх амьтад бий. 251 зүйл шувуу бүртгэгдсэн. Өмнөдийн дулаан орны шувууд Сибирь лүү нүүдэллэх замд буудаллан өнгөрдөг бүс учраас олон зүйл шувууг энд харах боломжтой.

Сум орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал

“Эм Би Эм Эс” ХХК -ийн “Алтны ил шороон орд” төсөл нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт оршдог.

Баяндун сум БНМАУ-ын Засгийн газрын шийдвэрээр 1925 онд Монгол улсын орон нутгийн захиргааны дүрмийн 33 дугаар заалтыг баримтлан 9 баг, 192 өрхтэй байгуулагдаж, Хан Хэнтий уулын аймагт харъяалуулсан байна. Дорнод аймгийн нутаг дэвсгэрийн умард хэсэгт байрлаж Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Баян-Уул сумдтай нутаг залган, ОХУ-тай 58 км нутгаар хиллэсэн 623.7 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай. Сумын төв Наранбулаг нь Улаанбаатар хотоос 669 км, Чойбалсан хотоос 176 км зайтай оршдог. Сумын

нутаг дэвсгэр нь Хан Хэнтий нурууны салбар уулсын төгсгөл, Эдрэнгийн нурууны зүүн хойд хэсгийн нам уулс, Дорнодын өндөрлөг талын баруун хойд хэсэгт хамаарна.

Ихэнх нутаг нь далайн түвшинээс дээш 900-1000м, хамгийн нам дор газар Улз голын хөндий 760 км, хамгийн өндөр Халиун уул 1378 м-т байрладаг.

Шинэс, нарс, хус, улиас, бургас голчлон ургадаг 27 978 га ойн сан, 964 га талбай бүхий нуур, цөөрөм, гол, горхийн усан сан бүхий байгальд чоно, үнэг, бор гөрөөс, буга, зээр, тарвага, гахай, дорго, илбэнх зэрэг ан амьтан, жигүүртэй шувуудтай. Мөн алт, цайр, хар тугалга, уран зэрэг ашигт малтмалын үлэмж нөөцтэй нутаг юм.

Баяндунчуудын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй, төмс, хүнсний ногоотой хослон эрхэлдэгт оршино. Энэ онд 11 га талбайд төмс тариалж 85,7 тн, 11,4 га талбайд хүнсний ногоо тариж 103 тн-ыг тус тус хураан авсан байна.

Дорнод аймгийн арван дөрвөн сумын нэг нь Баяндун сум юм. Засаг захиргааны анхан шатны нэгж 4 багтай, 658 өрх, 2873 хүн амтай, 66513 толгой талтай, төмс, хүнсний ногооны 25 га талбайтай. Улаанбаатараас 669 км, Чойбалсан хотоос 176 км-т оршдог. Тус сум хойт талаараа ОХУ, зүүн талаараа Дашбалбар, Сэргэлэн, баруун, баруун хойд талаараа Цагаановоо, Баян-уул сумтай хиллэдэг. Баяндун сум нь Хан Хэнтий уулын салбар хэсэг ойт хээрийн бүсэд оршдог. Д.т.д 900-1378 метрт өргөгдсөн. Үдийн нарны тусах өнцөг нь зуны туйл 6 сарын 22 нд 64.5, өдөр шөнө тэнцэх буюу 9 сарын 21-22 нд 41, өвлийн туйл 12 сарын 21 17.50 байдаг. Экватороос хойш 5420 км, хойд туйл хүртэл 4582 км, уртрагийн нэг градуст тулах зэргэдийн нумын урт нь 73.2 км. Зэргэдийн нийт урт 26352 км. Орших зэргэдийн тэнхлэгээ эргэх урд нь 1098 км/цаг болон 305 м/с байдаг. Нутгийн хойд хэсгээр ой мод элбэгтэй, уулархаг нутагтай, хамгийн өндөр өргөгдсөн цэг нь Халиун өндөр 1378 км-т оршино.

Газарзүйн байрлал гадаргын онцлог. Тус аймаг нь Монгол орны зүүн хэсэгт орших ба 123.6 мянган ам дөрвөлжин км нутагтай, хойд талаараа ОХУ-ын Өвөр Байгалийн хязгаар, зүүн талаараа БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр, Хянган аймгуудтай хиллэдэг, баруун урд, баруун талаараа Сүхбаатар, Хэнтий аймгуудтай хиллэдэг. Аймгийн төв Чойбалсан хот нь нийслэл Улаанбаатар хотоос 655 км зайтай. Тус аймгийн нутаг нь далайн түвшнээс дээш 560-1300 м өргөгдсөн ухаа, гүвээ бүхий тал нутаг юм. Нутгийн зүүн өмнөд хэсэгт Мэнэн, Тамсаг, Матадын өргөн талууд, Дорнод талын үзэсгэлэн болсон Буйр нуур, Хөх нуур, Яхь нуур зэрэг том, жижиг олон нуур цөөрмүүдтэй. Халх-Нөмрөгийн, Дорнод Монголын, Монгол Дагуурын дархан цаазат, Угтам, Тосон-Хулстайн байгалийн нөөц газар, Онон-Балжийн байгалийн цогцолбор газруудтай.

Өвөг дээдсийн түүхийг өгүүлсэн X-XI зууны Киданы үеийн Хэрлэн барс хотын туурь, Хэрмэн зам, XIX зууны үед хүний гараар бүтээгдсэн Утай таван уул, Их бурхант, Хүн чулуунууд, Угтамын хийдийн тууриудаас гадна 1939 оны Халх голын ялалтын хөшөөнүүд зэрэг түүхийн дурсгалт газрууд олонтой.

Нутгийн ихэнх хэсгээр тал хээрийн үлдмэл, өнчин, нам уулс, ухаа гүвээт толгод эзлэх ба баруун хойд хэсгээр Эрээний нуруу, зүүн хэсгээр Их Хянганы нурууны салбар захын уулс оршино. Энд 1000м-ээс дээш өндөртэй Хөх уул /1046м/, Хурам хан уул /1166м/, Хөгнө уул /1132м/, Өгөөмөр уул /1178м/, Буурал уул /1194м/, Баруун Матад /1246м/, Зүүн Матад /1050м/, Вангийн Цагаан уул /1099м/, Ламын хайрхан уул /1186м/, Соёлз уул /1504м/, Модтой хамар /1290м манай орны хамгийн зүүн захын цэг/ зэрэг уулс байна. Хээрийн бүсийн ухаа гүвээрхэг, толгодорхог болон тэгш тал үргэлжлэн орших учир газрын гадаргын хотгор гүдгэрийн ялгаа багатай. Нутгийн хамгийн өндөр цэг нь хоёр улсын хил дээрх Соёлз уул д.т.дээш 1504м өндөр, хамгийн нам цэг нь Хөх нуур д.т.дээш 560м, энэ нь манай орны хамгийн нам цэг билээ.

Гадаргын онцлогийг хотгор гүдгэрийн морфологи хэв шинжээр нь авч үзвэл өндөрлөг тал ба цав толгодын /1000-1500м/, намдуу талын /1000м-ээс доош/ хэв шинжид, геоморфологийн мужлалтаар Төв Азийн геоморфологийн их мужийн Монголын Дорнод мужийн Улз-Хэрлэнгийн, Баруун-Уртын, Мэнэнгийн талын, Тамсаг-Буйр нуурын, Нүхт давааны дэд мужид, Сибирийн геоморфологийн их мужийн Хэнтийн мужийн Эрээний

нурууны, Хянганы мужийн Халх голын дэд мужид тус тус хамаарна. Монгол орны байгалийн газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их муж, Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж, Их Хянганы уулархаг их мужид багтана. /Мужлалтыг З.Санжмятав “Монгол орны байгалийн газарзүй 2011 номноос авав”/.

Уур амьсгал. Монгол орон Ази тивийн төв хэсэгт дундад өргөргийн сэрүүн бүсэд орших ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. Тус аймгийн нутгийн ихэнх нь хээрийн бүсэд орших учир эх газрын эрс, тэс хуурайвтар уур амьсгалтай тал хээрийн шинж ноёрхсон байдаг.

Жилийн дундаж температур нутгийн хойд болон зүүн хэсгээр 00С – -20С, төв ба өмнөд хэсгээр 00С – +20С үзүүлэлттэй байна. Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур ихэнх нутгаар -200С, Халх голын сав дагуу -250С бол хамгийн их хүйтэн нь Халх голд -470С хүрсэн байна. Харин хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж температур 200С, хамгийн их халуун 410С хүрчээ. Тус нутгаар 50С хавар 4 дүгээр сарын 14-нөөс 5 дугаар сарын 1-ны хооронд дайран дулаарч намар 9 дүгээр сарын 27-ноос 10 дугаар сарын 13-ны хооронд дайран хүйтэрч нийтдээ 149-182 хоног 50С - аас дулаан үе үргэлжилдэг байна. Жилд нар гийгүүлэх хугацаа хойд хэсгээр 2700-аас бага цаг, төв ба зүүн хэсгээр 2700- 3000 цаг, өмнөд хэсгээр 3000-3200 цаг, зуны нэг өдөр 9-10 цаг, өвлийн нэг өдөр 5-6 цаг байна.

Жилд дунджаар 200-400 мм хур тунадас унах ба нутгийн баруун хойд Эрээний нуруу, зүүнд Дэгээ, Нөмрөгийн сав дагуу 300-500мм, бусад нутгаар 200-300 мм тунадас унадаг. Тогтвортой цасан бүрхүүл нутгийн баруун хойд ба хойд, зүүн хэсгээр XI сарын 15 – III сарын 20 хүртэл, бусад нутгаар XI сарын 20 – III сарын 10 хүртэл тогтдог. Агаарын даралт жилийн турш жигд 900–950гПа, зонхилох салхины чиглэл баруун, баруун хойд зүгээс байх ба жилийн дундаж хурд 4-6м/с түүнээс ч их байдаг манай орны салхи ихтэй нутаг юм.

Ус зүй. Тус аймгийн нутаг нь ус зүйн сүлжээний хувьд бүхэлдээ Номхон далайн ай савд хамаарна. Хэрлэн, Халх, Улз, Дэгээ, Нөмрөг, Гал, Дөч, Ямалхай зэрэг гол мөрд, Буйр, Хөх, Яхь нуур болон бусад олон арван жижиг нуур устай. Эмчилгээ сувилгааны ач холбогдол бүхий улсын болон аймаг орон нутгийн зэрэглэлтэй Утаат минчүүр, Хөх нүдэн, Ар булаг, Тамсаг булаг, Шувуут зэрэг 10 гаруй рашаан, Жирмийн цагаан, Хулстайн тосон, Булан шавар зэрэг 10 орчим эмчилгээний шавартай эрдэст нууруудтай. Эдгээр нь бүгд “Нүүрсхүчлийн хүйтэн” рашааны мужид багтдаг. Гол мөрний үндсэн тэжээл нь зуны хур бороо, гүний ус үлдсэн хэсгийг бүрдүүлдэг. Гол мөрөн, нуурын мөсний горим нь намар 11-р сарын сүүлчээр хөлдөж, хавар 4-р сарын дундуур гэсдэг байна.

Сумын нутаг дэвсгэр нь 623705 га, үүнээс бэлчээрийн газар 478411.5 га, хадлангийн талбай 33523 га, тариалангийн газар 32.4 га байна. Төв нь УБ хотоос 665 км, /Чойбалсан хотоос 176 км алслагдсан Наранбулаг суурин. Нутаг дэвсгэр нь уулын хар хүрэн, хар шороон, хужир мараат хам хөрс бүхий уулархаг гадаргатай. Бүрэн хаан (1348м), Баяндун (1298 м), Их газар (1287 м), Согоот (1229 м), Угтам (1237 м) гэх мэт уулстай. Өндөр цэг нь 1348 м, нам цэг нь 783 м (Улз голын эрэг). Улз гол түүний цутгал Бүс, Баян гол, Түргэн, Унагай, Билүүт, Урт гэх мэт гол, Түргэн цагаан, Онхоодой гэх мэт нууртай.

Эх газрын уур амьсгалтай. 1-р сарын дундаж температур -22”, 7-р сарынх +18”- 20”, жилд дунджаар 300 мм тунадас унадаг. Сумын хойт талын Нэмнэ, Тогоот, Халиун, Бэрх, Баян талын эхээр нарс, хар мод, хус, улиас, бургас элбэгтэй. Улз голоос урагших Их газар, Согоот, Тэмээн чулуун зэрэг газар хус, улиас, бага боловч ургадаг. Энд нэрс, мойл, улаагана, үхрийн нүд, нохойн хошуу, үрэл зэрэг жимстэй. Буга, бор гөрөөс, зээр, шилүүс, үнэг, хэрэм, туулай, чоно, хярс, өмхий хүрэн, дорго, тарвага гэх мэт ан амьтантай. Хадлан бэлчээрийн нөөц ихтэй. Хялгана, хиаг зэрэг хээрийн ургамал голлон ургадаг. Баяндун, Угтам, Хайрхан зэрэг тахилгат уул, овоотой.

Харилцаа холбоо: Сумын хэмжээнд Мобиком, Скайтел, Юнител болон үүрэн холбооны үндэсний оператор Жи-Мобайл компаниуд үйлчилж байгаагийн зэрэгцээ сумын төвд орон нутгийн телевизийн 6 сувгаар, кабелийн 3 телевизийн 100 гаруй сувгаар тус тус


нэвтрүүлэг дамжуулж байна. 2017 оноос Юнивишнийг хэрэглэгчид хэрэглэж эхлээд байна. Аймгийн хэмжээнд 0.7 мянган телефон цэг айл өрх, албан газар ашиглаж байна.

Хүн ам.Сум 3186 хүн ам, 902 өрхтэй бөгөөд засаг захиргааны 4 багт харъяалагдаж байна.

Хүснэгт № 13. Баяндун сумын хүн амын тоо /2018-2022 он/

Он	2018	2019	2020	2021	2022
Баяндун	3,095	3,103	3,138	3,195	3,186
1-р баг, Түргэн	706	756	782	775	777
2-р баг, Хайрхан	488	500	510	511	511
3-р баг, Яргай	577	588	598	601	598
4-р баг, Наран	1,324	1,259	1,248	1,308	1,301

Баяндун сумын хүн амын тоо 2022 оны жилийн эцсээр 3186 байсан ба үүнээс 4-р Наран баг хамгийн их хүн амтай буюу нийт хүн амын 40.8 хувийг эзлэх байгаа бол 2-р баг Хайрхан хамгийн бага хүн амтай буюу нийт хүн амын 16 хувийг эзлэж байна. Нийт хүн амын хүйсийн 51 хувийг эрэгтэй, 49 хувийг эмэгтэйчүүд эзлэх бөгөөд 0-14 насны бүлгийхэн 30.7 хувийг эзлэнэ.




Зураг № 9. Хүн амын тоо, насны бүлгээр 2022 он

Тус сум 902 өрхтэй ба үүнээс Наран баг 371 өрх, Яргай баг 162 өрх, Хайрхан баг 151 өрх, Түргэн баг 218 өрхтэй байна.



Зураг № 10. Өрхийн тоо, 2022 он

Мал аж ахуй: Нийт 272501 малтай ба үүнээс адуу 21000, тэмээ 285, үхэр 32376, хонь 143730, ямаа 75110 байна.



Зураг № 11. Малын төрлөөр эзлэх хувь, 2022 оны байдлаар

Боловсролын үйлчилгээ: Баяндун сумын ЕБС-д нийт 576 хүүхэд, бага ангид 293 хүүхэд суралцаж байгаа юм. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар урлагийн заал бүхий бага сургуулийн барилгыг 2024 онд ашиглалтанд оруулахаар барьж байна. /2023 оны 11 сарын 09-ны мэдээ/



Зураг № 12. Дорнод аймгийн Баяндун сумын албан ёсны сайт болон нүүр номын харагдах байдал /2024 оны 01 сарын 09-ны өдрийн байдлаар/



Зураг № 13. Дорнод аймгийн Баяндун сумын засаг захиргааны нэгжийн зураг

**3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ
ТОДОРХОЙЛОЛТ**

Хүснэгт № 14. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим хугацаа

Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Сөрөг нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
Нэг. Төслийн үйл ажиллагааны явцад				
ШТМ, ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Гүний ус, ургамал	Төслийн талбай	Бага	Төсөл хэрэгжих хугацаанд
Зам, жим харгуй ихсэх	Агаар, хөрс, амьтан,	Авто зам түүний ойр орчим	Дунд	
Олборлолтонд өртөх	Газрын хэвлий	Төслийн талбай	Дунд	

Хүснэгт № 15. Гол нөлөөллийн дүн шинжилгээ

Нөлөөллийн ангилал	Гол нөлөөлөл	Нөлөөллийн цар хүрээ	Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн үргэлжлэх хугацаа
1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Эвдэх • Доройтуулах	Санамсаргүй алдаа гарсан тохиодолд автомашины тос алдаж хөрс, шороо бохирддог. Хөрс эвдэх нөлөөлөлд уурхайн хөрсийг дураараа сэндийчих, барилга өргөтгөн барих ажлууд хамаарагдаж байна. Доройтуулах нөлөөлөлд автомашины хүн тээврийн маршрут, хог хаягдлын төвлөрсөн цэгийг хашаалаагүй зэрэг хамаарагдаж байна.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Хөрс бохирдуулах нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. Хөрс эвдэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна. Хөрс доройтуулах Нөлөөллийн эрчим дунд зэрэг эрчимтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Нөөцийг бууруулах	Үйл ажиллагааны явцад гүний усыг бохирдуулах нөлөөлөл нь ШТМ асгарах зэрэг орно. Газрын гүний ус ашигладаг учраас нөөцөд бага зэрэг нөлөөлнө.		Газрын гүний усны нөөцийг бууруулах нөлөөллийн эрчим их байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл • Амьдрах орчинг хуваах • Амьдрах орчинг доройтуулах • Амьдрах орчинг хомсдуулах • Нөөцийг бууруулах	Хүнд даацын хөдөлгөөн нь тэдгээрийн амьдрах орчныг хуваах, доройтуулах, хомсдуулах нөлөөллийг үзүүлж байна.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөллийн эрчим их хэмжээтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
4. Агаарт үзүүлэх нөлөөлөл • Бохирдуулах • Тоос	Галлагааны зуухаас угаар, автомашины шатаасан хийн угаар нь агаарыг бохирдуулж түүний чанарыг доройтуулдаг. Замын барилгын ажил нь агаарт тоос дэгдээж сөрөг нөлөө үзүүлдэг.	Төслийн эдэлбэр газрын хэмжээ	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд зэргийн эрчимтэй байна.	Төсөл хэрэгжих хугацаанд
5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс • Хамгаалах • Нүүлгэн шилжүүлэх	-	-	-	-

Эндээс үзэхэд тус төслийн эдэлбэр газар төдийгүй орчны газар нутгийг хамгаалалтад авч, авто хөсгийг зөвхөн тогтоосон замаар явуулж, үйлчлүүлэгчдийн тоог тогтоосон норм хэмжээнээс давуулахгүй байхыг үл харгалзваас хөрсний өнгөн хэсгийг дагтаршуулах, талхлах, ургамал нөмрөгийг алдралд оруулах улмаар ургамлын төрөл, зүйл хомсдож, ургацын хэмжээ буурч, экологийн тэнцвэрт байдал алдагдахад дөхөм үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Дээрх нөлөөллийн хүчин зүйлүүдээс хамгийн их нь хүнд даацын автомашины хөл хөдөлгөөн ихсэх, төслийн орчимд түймэр алдах, тээврийн хэрэгслээр холхиж олон салаа зам гаргаснаас хөрс эвдрэх, ахуйн бохир ус, хатуу хог хаягдал хур борооны усаар угаагдаж хөрсөнд шингэх, шатах тослох материал асгарах нь хөрс, усны бохирдол, ургамлан нөмрөг алдралд орон хомсдож биомассын хэмжээ багасах зэрэг ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болох нь харагдаж байна.

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах бүлэгт өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

3.1 ТӨСЛИЙН ГАДААД БОЛОН ДОТООД ОВООЛГО БАРЬЖ БАЙГУУЛАХ ҮЕИЙН ГОЛ НӨЛӨӨЛӨЛ

- Гадаад болон дотоод овоолгыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, кемпийг барих явцад хөрс, ургамал механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах
- Будаг, маажин, цавуу мэтийн химийн бодис асгарснаас хөрс ургамал, хөрсний ус, голын ус бохирдох, амьд организм хордох
- Нунтаг болон цементийн зуурмаг, шохой асгаж, модны зомгол, золтос, үйрдэс, шилний хагархай зэрэг элдэв төрлийн хог хаягдлаар орчныг бохирдуулах
- Төслийн талбайн хөрс, ургамал бүхэлдээ эвдрэл, элэгдэлд орно.

3.2 ГАДААД БОЛОН ДОТООД ОВООЛГО БАЙГУУЛСНААС ХОЙШХИ ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ НӨЛӨӨЛӨЛ

- Объектын орчин тойронд хөрс, ургамлан нөмрөг элэгдэл, эвдрэлд орох
- Зам жим, барилга байгууламжийн орчны хөрс талхлагдах, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, үйлчлүүлэгчдийн тоо олширсноор голын эрэг бохирдох
- Автомашины хөдөлгөөн нэмэгдсэнээс агаар орчин бохирдох зэргээр илэрнэ.

Төслийн байгууламжийг барих эхний үе шатанд объектыг байгуулах, газар шорооны ажил гүйцэтгэхэд тухайн орчны хөрс, ургамал нэн түрүүнд өртөж, суваг шуудуу татах зэрэгт рельефийн зарим хэлбэрийн үндсэн төрх алдагдах, шинээр бичил хэлбэр бий болж, газрын хөрсний механик бүтэц, ургамлын бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Ийм тохиолдолд тухайн байгууламж барих хэсгийн өнгөн хөрсийг хуулж овоолго хийж нөхөн сэргээлт болон цэцэрлэгжүүлэлтийн ажилд ашиглах нь зүйтэй. Нөхөн сэргээхдээ төсөлд тусгасан зураг төслийн дагуу тухайн орчинд зохицсон ургамал тарих шаардлагатай. Овоолго барих үеийн нөлөөллийн төрөл нэлээд олон байгаа хэдий ч хамрах хүрээ нь бага, эрчим нь их байна. Иймд байгууламжийг барьж дууссаны дараа нөхөн сэргээх ажлыг яаралтай хийх шаардлагатай. Ашиглалт жигдэрсний дараа орчинд үзүүлэх нөлөөллүүд нь түүний олон талт үйл ажиллагаатай уялдан хүрээгээ тэлэх магадлалтай байгаа нь ажиглагдаж байна.

Тус төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллийг бүхий л хүрээнд авч үзвэл: хөрс дагтарших, элэгдэх, эвдрэх нөхцөл бүрдэх, голын ус болон эрэг бохирдох, хөрсний усаар дамжин гүний ус бохирдох, биомассын хэмжээ багасах, элдэв төрлийн бохирдлоос амьтан, ургамал ялангуяа хөрсөн дэх бичил биетэн, хорхой шавьж хордож устах, мөлхөгч, мэрэгчид, жигүүртэн шувууд дайжих, мод бут өвс ургамал механик гэмтэлд өртөх гэж үзэв.

Эдгээр сөрөг нөлөөлөл нь нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, байгаль орчныг хамгаалах болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан асуудлуудад хайхрамжгүй хандсанаас үүсч болно. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг

дараах бүлэгт дэлгэрэнгүй оруулсан бөгөөд тус зөвлөмжийг төсөл хэрэгжүүлэгч цаашид мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

3.3 ТӨСЛӨӨС АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих орчимд агаарын бохирдол харьцангуй бага байна гэж үзэж байна. Энэ нутгийн агаар, ус, хөрс, ургамал байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан бөгөөд ялангуяа уг төсөл хэрэгжих талбай нь хүний суурьшилын бүсээс зайтай, тухайн орчимд агаар орчинд хүчтэй нөлөөлж бохирдуулах эх үүсвэр байхгүй учир тухайн төсөл хэрэгжих талбайн агаар нь харьцангуй цэвэр ба төслийн үйл ажиллагаанаас суурьшлын бүсэд үзүүлэх сөрөг нөлөө харьцангуй бага байна.

Төсөл хэрэгжих орчмын агаарын бохирдлын эх үүсвэр нь барилга байгууламж барих явцад үүсэх тоосжилт, барилгажилтанд ажиллах машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ зэрэг болно.

Мөн агаарын бохирдлын гол үүсвэрийн нэг нь байгалийн хүчин зүйл болох шороон шуурга гэж болно. Чухам ийм үед л тоос, шороо ихээр дэгдэж агаар орчныг бохирдуулна.

Цаашид уурхайн тээврийн хэрэгслийн ирж очих машин механизмуудын түлшний шаталтаас үүсэх хорт хий, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөллийг бага хэмжээгээр үзүүлэх болно.

Дээрх нөлөөллийн хэлбэрийг доор дурдсан байдлаар ялган төсөөлж болох юм. Үүнд:

- Ургамалын бүрхүүл, бэлчээр тоос шороонд дарагдах
- Агаар дахь тоосны агууламж ихсэн хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлөх

Иймд төсөл хэрэгжих орчин нь уул уурхайн бүс гэдгийг харгалзан үзэж хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга зам, хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлох нь нэн чухал юм.

Тээвэрлэлтийн /уурхайн олборлолтын/ үед эвдэрсэн газрыг тухай бүр нөхөн сэргээх, аль болохоор олон салаа зам гаргахгүй байх, автомашин зорчих гол замыг цаашдаа хатуу хучилттай болгох зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.

Хийн хаягдлаас үүсэх гол сөрөг нөлөөлөл

Автомашин утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцдог. Зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310г, дизель хөдөлгүүр 80-100г хорт бодис ялгаруулна. 1кг шатахууныг литрт шилжүүлэн (бензин $q=0.725$, дизель $q=0.825$) бодож, түүний шаталтаас ялгаран гарах хорт хийн агуулалт, хэмжээг тооцоолон гаргасан. Автомашин утааны агаарыг бохирдуулах чанарыг тодорхойлохдоо бензин хөдөлгүүрт бол нүүрстөрөгчийн ба азотын ислийн агууламжийг, дизель хөдөлгүүрт бол хөө тортогийн агууламжийг үндсэн үзүүлэлт болгодог.

Хүснэгт № 16. Автомашин асаалттай байх үеийн ялгаруулах хийн хэмжээ

Бохирдол	Автомашин асаалттай, сул зогсолттой байх үед	Машин хурдтай явж байх үед (60 км/цагаас дээш)	Машин тойргоор эргэх үед	Машины хурд саарч байх үед (60 км/цагаас доош)
CO (%)	4 – 9	< 1 – 8	1 – 7	2 – 9
HC, C ₆ H ₁₄ (ppm)	500 – 1000	50 – 80	200 – 800	3000 – 12 000
NO _x (ppm)	10 – 50	1000 – 4000	1000- 3000	5 – 50

Дээрх хоёр төрлийн хөдөлгүүрийн утааны дундаж найрлагыг дараах хүснэгтэд харуулав. Энэ нь байгаль орчинд цацагдаж байгаа утааны техникийн болон мониторингийн хяналтын үзүүлэлт, ашиглагдах ач холбогдол юм.

Хүснэгт № 17. Автомашины утааны бүрдэл найрлага

№	Бүрдэл	Хөдөлгүүрийн төрөл		Тайлбар
		Бензин	Дизель	
1	Азот (%)	74-77	76-78	Хоргүй
2	Хүчилтөрөгч (%)	0.3-8	2-18	Хоргүй
3	Усны уур (%)	3-5.5	0.5-4	Хоргүй
4	Нүүрсхүчлийн хий (%)	5-12	1-10	Хоргүй
5	Нүүрстөрөгчийн исэл (%)	1-10	0.01-0.5	Хортой
6	Азотын исэл (%)	0.1-0.5	0.001-0.4	Хортой
7	Альдегид (%)	0.0-0.2	0-0.009	Хортой
8	Нүүрс-устөрөгчид (%)	0.01-0.02	0.01-0.5	Хортой
9	Хүхэрлэг хий (%)	0-0.002	0-0.03	Хортой
10	Хөө тортог (г/м3)	0-0.44	0.01-1.1	Хортой
11	Бенз (а) пирен (г/м3)	<0.00002	<0.00001	Хортой

Хүснэгтээс харахад, 1л бензин шатаахад ялгарах хорт бодисын хэмжээ нь дизель түлшнийхээс дунджаар 3.1 дахин их байгаа бөгөөд зөрүүгийн хэмжээ нь 3-4 хооронд хэлбэлзэж байдгийг судалгаагаар тогтоосон байна.

3.4 ТӨСЛӨӨС ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Уг төсөл хэрэгжих талбай нь байгалийн хүчин зүйлс болох ус, салхины нөлөө, мөн хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр газрын гадарга болон хэвлийн их хэмжээний эвдрэлтэй, ихэнх хэсэг харьцангуй унаган төрхөө хадгалсан, хэсэг газар ургамал хөрс талхлагдаж, ухмал нүх үүссэн, одоогийн байдлаар бага зэрэг хог хаягдалтай байна.

Тус төсөл хэрэгжихэд нийт талбайн 5% буюу 15.9 га талбайн гадаргуу өртөгдөж байгаль орчинд сөрөг нөлөө учруулна.

 Төслийн олборлолтын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Газрын хэвлий ухах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихсэх, үүнээс үүдэн хөрс дагтарших, эвдрэх, ургамал нөмрөг алдралд орох, улмаар хөрсний үржил шимт хэсэг устаж алга болох, механик бүрэлдэхүүн өөрчлөгдөх, үүний улмаас элсэнцэр хөрс салхинд хийсэх, элсжилт үүсэх
- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр газрын гадарга, хэвлий бохирдох
- Болзошгүй тохиолдлоор гал алдах, түймэр гарах

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх шаардлагатай.

3.5 ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй газар нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрлах Халчиг Өндөр уулын хаяа уулсын системд байрлах “Эм Би Эм Эс” ХХК-ийн XV-21786 тоот тусгай зөвшөөрөл бүхий хайгуулын талбай нь хөрс-газарзүйн мужлалаар Төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн өндрийн бүсшилийн хэв шинж бүхий Хэнтийн мужийн Хэнтийн зүүн 40-р тойрогт багтана (Үндэсний атлас, 2022). Төслийн үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчинд учруулж болзошгүй нөлөөллүүдийг жагсаан үзүүлбэл:

Төслийн кемпийн барилгын ажлын үед хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Байгууламжийн материалыг газар дээр нь зөөвөрлөн байрлуулах, төсөл хэрэгжих явцад хөрс, ургамал, мод бут механик гэмтэлд өртөх
- Овор ихтэй хүнд ачаан (материал) доор удаан байсан хөрс дагтарших, ургамал дахин ургах чадваргүй болох, устах гэх мэт орно.

Төслийн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсийг бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын хөрсийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.

3.6 УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Уурхайн олборлолт болон төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр /тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг/ зүйлийн бүрдлийн хэвийн байдалд өөрчлөлт гарч, орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдаж, тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устгах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно.

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төсөл орчмын ургамлан нөмрөгийн тусгагын бүрхэц сийрэгжин халцгай талбайн хэмжээ ихсэх, бэлчээр талхлагдах,
- Тус районы үндсэн ургамлууд нь нөхөн сэргэх чадваргүй болж устгах аюулд орох ба өөр ургамлын зүйлүүдээр солигдох болно. /Хогийн ургамал/
- Төсөл орчмын мод бут механик гэмтэлд өртөх

3.7 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн талбайн район монгол орны Хөхтөн амьтдын тархцын газарзүйн мужийн 3-р муж буюу Баруун хянганы тойрогт хамаарагдана.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Техникийн шатах тослох материал асгарах, ахуйн хог хаягдал, бохир усны нөлөөгөөр бичил биетэн устгах, хордох
- Төслийн олборлолтын ажлын үеийн тэсрэлт болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн дуу чимээ зэргээс тухайн орчны амьтад үргэн дайжиж амьтны аймагт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

3.8 ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Гадаргын болон гүний усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд, бичил бохир цэвэрлэх байгууламжаас гарсан цэвэршүүлсэн усыг тоосжилт болон ногоон байгууламжийн усалгаа зэрэгт эргүүлэн ашиглах, үер болохоос сэргийлж далан байгуулах, голын ойр орчимд ахуйн болон үйлдвэрийн бохирдлоос сэргийлэх хамгаалалтын төлөвлөгөө, анхааруулга сэрэмжлүүлэг бүхий самбар, мөн гүний ус ашиглалтыг хянах, хэрэглээг багасгах, гүний усны цооног болон гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг багтана.

Төслийн үйл ажиллагаанаас гадаргын болон газар доорх усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

- Төслийн үйл ажиллагааны явцад машин механизмаас мөн хүний санамсаргүй үйл ажиллагаанаас шалтгаалан ямар нэгэн шатах, тослох материал хөрсөнд ил задгай асгарч, хөрсний ус болон борооны усаар дамжуулан гол горхи бохирдуулах
- Төслийн ойр орчимд хүний үйл ажиллагаатай холбоотойгоор хог хаягдал бий болж ойр орчмын гол горхины ус ба түүний эргийг бохирдуулах, хөрс суларч цас борооны усанд норж шавар шалбааг ихтэй, хуурай салхитай үед тоос шороо босч орчныг бохирдуулах зэргээр нөлөөлнө.
- Голын усны горим хүний үйл ажиллагааны нөлөөгөөр урсацын горимын үйл ажиллагаа алдагдах

3.9 Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн үйл ажиллагаа нь улс орон нутгийн төсөвт багагүй орлого оруулах, зуны улиралд ажлын цөөнгүй байр гардаг нь ажилгүйдлийг багасгах, хүмүүсийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх чухал хүчин зүйл болж байна. Тухайн орон нутгийн экологийн чадавхаас хэтэрсэн ажил үйлчилгээ эрхлэх хэт олон том жижиг уурхай байгуулж хүн амын төвлөрөл бий болгох хөл хөдөлгөөн ихэсгэхээс аль болохоор зайлсхийх, бүс нутгийн дүрэм журмын дагуу зохих хязгаарлалт хийх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд нэгэнт байгуулагдсан болон байгуулах гэж буй уурхай нь байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хамгийн бага хэмжээнд хүртэл нь бууруулах талаар туйлын хариуцлагатай хандаж идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Төслийн олборлолтын ажлын тоос болон дуу чимээний нөлөө нь ойролцоо оршин суугч иргэдэд нөлөөлөл үзүүлэх болно. Оршин суугч иргэдийн ашигладаг худгийн ойролцоо гүний усыг ашигласнаар бага гүний усны түвшин буурч энэ нь ойролцоох өрхүүдэд шууд нөлөөлж болзошгүй. Төслийн байгууламжийн ойр зорчих тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнээр зам тээврийн осол үүсгэхэд нөлөөлж болзошгүй.

3.10 ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛӨЛ

“Эм Би Эм Эс” ХХК-ийн алтны шороон орд төсөл нь Дорнод аймгийн Баяндун сумын нутагт байрлах ба төслийн зүгээс хүрээлэн буй орчин, нийгэм эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөг тодорхой хэмжээгээр үзүүлэх юм. Үүнээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь энэ төслийн сөрөг нөлөөтэй уялдан газар ашиглалт, хөрсний бохирдол, хөрсний талхагдал, агаарын чанар, ан амьтны дайжилт, ургамлан нөмрөг доройтох зэргээр хуримтлагдах нөлөөллийг үзүүлнэ. Иймд эдгээр хуримтлагдах нөлөөллөөс өөрийн нөлөөллийн байдлыг ялган салгахын тулд нөлөөллийн бүсэд тогтоосон БОМТ-г цаг тухай бүрд нь авч хэрэгжүүлж, тайлагнах нь зүйтэй.

Төсөл хэрэгжих явцад уурхайн олборлолт, төслийн цаашдын үйл ажиллагааны явцад тухайн төслийн үйл ажиллагаа болон орон нутагт хэрэгжиж буй бусад төслийн үйл ажиллагаанаас хам нөлөөлөл үүсч, байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд сөрөг үр дагавар ихтэй, богино болон урт хугацааны нөлөөллийг үүсгэж болзошгүй.

Хүснэгт № 18. Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл

№	Хуримтлагдах нөлөөлөл	Нөлөөллийн шалтгаан	Хамрах цар хүрээ	Үргэлжлэх хугацаа
1	Газрын гадарга ба хэвлий эвдрэлд өртөх	Бусад төслүүдийн нөлөөлөл	Төслийн талбай, нөлөөллийн бүс	Өнгөрсөн, одоо, ирээдүй
2	Газрын доорх усны нөөц багасах	Бусад төслүүдийн усны хэрэглээ, хэрэглээний давхцал		Одоо, ирээдүй
3	Гадаргын ус бохирдох	Бусад төслүүдийн нөлөөлөл		Өнгөрсөн ирээдүй, одоо,
4	Ургамлан нөмрөгийн доройтол	Уур амьсгалын өөрчлөлт, төслийн үйл ажиллагаа		Өнгөрсөн, одоо, ирээдүй
5	Агаарын бохирдол нэмэгдэх	Хуурайшилт, бусад төслүүдийн бохирдол		Өнгөрсөн, одоо, ирээдүй
6	Хөрсний бохирдол, элэгдэл үүсэх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй
7	Амьтан дайжих, тоо толгой цөөрөх	Уур амьсгалын өөрчлөлт, Бусад төслүүдийн нөлөөллийн давхцал		Өнгөрсөн, одоо, ирээдүй

Хуримтлагдах нөлөөлөл, түүний үр дагаварыг бодитой тодорхойлох, эрт хугацаанд илрүүлэхийн тулд төслийн үйл ажиллагааны тодорхой үе шат хэрэгжсэний дараа төслийн үйл ажиллагаанд мониторинг хийхийг зөвлөж байна.

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Эм Би Эм Эс” ХХК нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 08	Сар 09	Сар 10		
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлт батлуулах	-	захиалга	хүлээлцэх		Байгаль орчны мэргэжилтэн	
2.	Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөл байгуулах	-	захиалга	хүлээлцэх	хүлээлцэх	Байгаль орчны мэргэжилтэн	
3.	Аюултай болон энгийн хог хаягдал зайлуулах гэрээ байгуулах	-	захиалга		хүлээлцэх	Байгаль орчны мэргэжилтэн	
4.	Гамшиг болон эрсдлийн үнэлгээ батлуулах	-	захиалга		хүлээлцэх	Байгаль орчны мэргэжилтэн	
5	Галын дүгнэлт гаргуулах	-	захиалга		хүлээлцэх	Байгаль орчны мэргэжилтэн	
	Нийт	-					

5 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Эм Би Эм Эс” ХХК нь алтны шороон ордын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөлөө.

Хүснэгт № 19. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Зардал сая.төг (2 дахь жил)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйл ажиллагааны үе шатанд	Агаарын чанар	Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох	Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг усалгаа хийх, тусгай материал тороор хучих, ургамалжуулах зэргээр тоосжилт бууруулах арга хэмжээ авах	Уурхайн талбайд	500.0	Төслийн хугацаанд	-
	Гүний ус	Бохир ус дамжуулах шугам хоолойг зариулалтын бус материалаар хийх,	Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа	Төслийн хүрээнд	500.0	Төсөл хэрэгжих үед байнга	Усны тухай хууль MNS 2662-2002

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		шугам хоолойд гэмтэл үүсэх зэргээс гүний усыг бохирдуулах	эсэхийг үе үе хянах, тухай бүр нэн даруй засвар хийх				
Хөрсөн бүрхэвч		Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан сэргийлэх	ШТС болон авто зогсоол засварын цэгүүдийн талбайг бетондох арга хэмжээ авах, Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах https://hsct.mn/	Уурхайн талбайд	Дотоод төсөв		-
Ургамалан нөмрөг		Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох	Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх, замын нэгдсэн сүлжээг гаргах	Уурхайн талбайд	397.0	Жилд 2 удаа	-
Амьтны аймаг		- Уурхайн ухаш болон уурхайн талбайд зэрлэг амьтад нэвтрэх, улмаар нүх рүү унаж гэмтэх, хог хаягдлаас хордох - Нөхөн сэргээлтийг журмын дагуу хийгээгүйгээс амьдрах орчин доройтох - Уурхайн ажилчид хууль бусаар амьтан агнах үйлдэл гаргах	- Уурхайн овоолго болон ухашын гадуур хамгаалах хайс, тор татах - Ажилчдад амьтны тухай хууль, байгаль хамгаалах талаар сургалт хийж байх	Уурхайн талбай, баяжуулах үйлдвэрийн орчимд	Урсгал зардлаар	Төслийн хугацаанд	Амьтны тухай хууль
		Амьтан хамгаалах	Шувууны шувууны суулт 2 ширхэг /үүр/ суурилуулах	Уурхайн ухаш, баяжуулах, зогсоол орчимд	100.0	2 удаа	Амьтны тухай хууль
Нийт					1497.0 (Нэг сая нэг зуун мянган төгрөг)		

6 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Техникийн нөхөн сэргээлт гадаад овоолго Өөрийн техниктэй	4.8 га газарт гадаад овоолго үүсгэнэ	га	4.8		8,000.0	-	MNS 5917 : 2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
2.	Техникийн нөхөн сэргээлт дотоод овоолго -Өөрийн техниктэй	0.05 га талбай хамарна. Олборлолтын үед	га	0.05		Үйлдвэрлэлийн зардалд шингэсэн	2025 он	

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		дотоод овоолго үүсгэж явна						
3.	Тэрбум мод тарих	Төслийн талбайд салхин доод талдаа модоор хашлага хийх (Тайлбар: “Улаанбаатар хотын 2014 онд тарилтад тэнцэх мод сөөгийн тарьц, суулгачын ААНБ-ын судалгаа” “Тоонот байгаль” ТББ-ын үнийн дүнгээр авав.)	ширхэг	100	5000	100ш x 5000Т=500.0	2025 он	-
4.	Биологийн нөхөн сэргээлт - шимт хөрс	1.6 га газарт шимт хөрсний овоолго үүсгэнэ	га	1.6	2500.0	7000.0	2025 он	MNS 5914: 2008 Байгаь орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
	Нийт					15500.0		

7 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
3	Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах	Багийн түвшинд орон нутгаас чиглэл өгсөн газар хужир, мараа, өвс тавьж өгөх	-	-	-	10,000.0	2025 онд	-
	Нийт					10,000.0		

8 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн ашиглалтын нөлөөллийн бүсэд малчдын хаваржаа болон зуслан, намаржаа байхгүй.

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

9 ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

10 ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ажилчид болон үйлчлүүлэгчийн бие өвдөх, халдварт өвчин гарах	Ажилчдад ХАБЭА-ны ажлын хувцас, малгай, хошуувч, гутал	Нийт ажилчид	74	100.0	Дотоод төсөв	Өдөр бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2022-11-11 нэмэлт
2.	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр уурхайн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах /, утааны мэдрэгч, гал гарсан тохиолдолд ашиглах зориулалттай галын автомат гидрант, аврах шат, хаалга, тэдгээрийн байршлын тойм зураглал, яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбоо зэргээр бүрэн тоноглох/	Уурхайн хотхон	-	-	888.0	2025 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль 2015.12.04 нэмэлт шинэчилсэн найруулга
Нийт						888.0		

11 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж хаях	Хог хаягдлын цэг	-	200.0	3	600.0	2025 оны 7 сард	Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017.05.12
2.	Үйлдвэрийн	Уул уурхайн олборлолтын талбайн орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд	Уурхайн тосгон	-	-	-	Дотоод төсөв	2025 оны 7 сард	

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		хогийн сав байрлуулах, Байр сууц бүрт орчинтойгоо зохицсон материал, өнгө үзэмж бүхий хогийн савтай байх							
3.	Аюултай	Нэг удаагийн хэрэглээний зүйлээс татгалзаж, дахин ашиглах, Аюултай хог хаягдал аккумулятор, ашигласан тос маслыг цуглуулах тусгай хаягдлын цэг бий болгох	Хог хаягдлын цэг	-	-	-	Дотоод төсөв	2025 оны 7 сард	
	Нийт						600.0		

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэрээр нь барилгын болон ажилчдын буюу ахуйн гэж хоёр ангилна. Шинж чанараар нь хатуу, шингэн, хий гэж хувааж болно.

Төслийг хэрэгжүүлэх явцад барилгын ажилчдын түр суурин байгуулах ба үүсэн гарах ахуйн хог хаягдлыг дараах журмаар зохицуулна. Ялгаатай гурван өнгийн хог ангилан цуглуулах савыг барилгын ажилчдын түр сууринд байрлуулна. Доорх хүснэгт үзүүлсэн хаяг болон зааврыг сав бүрд байрлуулна. Эдгээр саванд хогийг зааврын дагуу ангилан хийж байгаа эсэхэд тухайн төслийн байгаль орчин эсвэл эрүүл ахуйн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

	Өнгийн шил, гэрлийн шил, толь, цонхны болон бусад шил хийхийг хориглоно!!!!
	Цаас болон бусад сонин сэтгүүл, цаасан хайрцаг, уут гэх мэт цаасан бүтээгдэхүүн, ус үл нэвтрүүлэх хайрцгууд. Эдгээрийг хогийн саванд хийхийн өмнө хавтгайлж нугалж хийнэ!!!
	Төмөр, хуванцар сав, баглаа боодол болон хуванцар сав хийнэ. Резин болон гялгар эдийг хийхгүй!!!

Зураг № 14. Хогийн савны төрөл

Хогийн саванд тавигдах шаардлага: (Хог хаягдлын тухай хууль)

15.1.1.хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2.галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3.хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

Хог хаягдал түүнийг цэвэрлэх, зайлуулах болон зохицуулах хэлбэр:

- Хог хаягдлыг орон нутгийн нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх талаар гэрээ байгуулж, холбогдох татвар хураамжийг цаг хугацаанд төлөх
- Ангилсан хог хаягдлаас боломжтой хэсгийг хоёрдогч түүхий эдийн цэгүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тогтмол тушаана.
- Барилгын ажлыг гүйцэтгэх явцад гарах хатуу хог хаягдлыг мөн түр цуглуулах цэгийг байгуулж хамгаалалтын хашаа, бункерт хийнэ. Ингэхдээ хууль, журмын дагуу энгийн, хяналттай, аюултай шинж чанараар нь ангилж хадгална. **Үүнийг хог хаягдал тээвэрлэх, үстгах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр түшааж байна.** Төслийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн хог хаягдлыг тушаасан талаарх тэмдэглэлийг тогтмол бүртгэнэ.
- Шатах тослох материалын сав, ахуйн цэвэрлэгээ, ариутгалын бодисын сав, баглаа боодлыг мөн тусад нь цуглуулна.
- Шингэн хаягдал болон бохирын асуудлыг Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын дагуу бохирыг соруулж зөөвөрлөх боломжтой байхаар зохион байгуулах
- Бохирыг соруулах, зөөвөрлөх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах.

12 ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар: Агаарын тоосны (TSP, PM10, PM2.5) шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх Агаарын бохирдлын (NO2, SO2, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар.	Төслийн талбайн авто зогсоол, Ухашны салхин доод талд	Тоосны хяналт: Төслийн талбайд 2 цэгт 1 удаадаа Өдөрт 2 удаа Агаарын найрлага: буюу жилд 1 удаа 7 сард	Шинжилгээний зардал 1 удаагийнх 30.0 х өдөрт 2 удаа х 2 цэг х 1удаа = 120.0 төгрөг зарцуулна.	MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2	Усны хяналт шинжилгээ: Усны чанар: pH, ууссан нийт давс (жингийн аргаар), нийт хатуулаг (CaCO ₃), Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө, нүүрсустөрөгчид (нефть бүтээгдэхүүний бохирдол)	Худаг: Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас Хаягдлын сан	Жил бүр 7 сард	жилд 2цэг (25+85.0) = 110.0 “Нарт шүүн лаборатори”-ийн 2025 оны тариф	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
	Усны түвшин (газрын гадаргаас доош, м-ээр)	Унд ахуйн усыг хангаж буй гүний худагт	Ус ашиглахаас өмнө нэг удаа, ус ашиглах явцад сар бүр, ашиглалт дууссаны дараа нэг удаа	-	
3	Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбайн хог хаягдлын цэг болон ариун цэврийн байгууламжийн цэгт хөрсний хүнд металл болон эрүүл ахуйн бактерийн холимог дээж авах ШТС болон автомашиг зогсоол хөрсний хүнд металлын дээж Шимт хөрс Биологийн нөхөн сэргээлтийн дараа хөрсний агрохими	Төслийн үйл ажиллагаа дуусахаас өмнө 1 удаа, Жил бүр 7 сард	Нийт 3 цэгт, нийт 5дээж = 125.0 /Хөрсний химийн шинжилгээ 1дээж- 25.0₮, хүнд металлын шинжилгээ 1дээж – 25.0₮, бактериологи 1дээж – 25.0₮/ “Нарт шүүн лаборатори”-ийн 2025 оны тариф	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн				355.0	


Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт № 20. Төслийн талбайн мониторингийн хяналт шинжилгээний цэгүүд

Мониторингийн ургамал, хөрсний дээж авах байршил					
Байршил	Зүсэлт	Гүн см	Хөрсний хэв шинж	Координат	
Уулын хажуу	Зүсэлт-1	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 24' 15.110" E	49° 31' 0.305" N
Ам хөндий	Зүсэлт-2	0-20	Карбонатгүй харшороон	113° 26' 7.362" E	49° 30' 48.018" N
Хамрын орой	Зүсэлт-3	0-20	Уулын хээрийн нимгэн хархүрэн	113° 24' 45.635" E	49° 30' 18.563" N
Талхлагдсан хөндий	Зүсэлт-4	0-20	Талхагдалд өртсөн хөрс	113° 26' 31.808" E	49° 30' 20.297" N
Толгодын хажуу	Зүсэлт-5	0-20	Карбонатгүй хар шороон	113° 26' 13.135" E	49° 29' 12.355" N
Толгодын хажуу	Зүсэлт-6	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 26' 59.647" E	49° 28' 56.466" N
Уулын хажуу	Зүсэлт-7	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 26' 15.151" E	49° 29' 40.906" N
Ам хөндий	Зүсэлт-8	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 24' 28.541" E	49° 30' 38.624" N
Ам хөндий	Зүсэлт-9	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 25' 8.900" E	49° 30' 8.014" N
Уулын хажуу	Зүсэлт-10	0-20	Уулын хээрийн нимгэн хархүрэн	113° 25' 2.927" E	49° 30' 47.270" N
Ам хөндий	Зүсэлт-11	0-20	Толгодын нимгэн хархүрэн	113° 25' 47.053" E	49° 30' 17.994" N

№	Шинжилгээ авах байршил	Мониторингийн цэг
Агаарын сорьц шинжилгээ		
1	Байгалиараа эрүүл талбай	113° 24' 15.110"E 49° 31' 0.305" N
2	Тээврийн зам орчимд	113° 26' 31.808"E 49° 30' 20.297"N
3	Кемп орчимд	113° 25' 2.927" E 49° 30' 47.270"N
Усны шинжилгээ		
7	Худаг	106°34'10.19"E 49°12'57.52"N

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг № 15. Мониторингийн цэгүүдийн зураг

13 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 08	Сар 09	Сар 10		
	1	2	3	4	5	6	7
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлтийн тайланг хугацаандаа танилцуулах, батлуулах	-	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	Гүйцэтгэх захирал	АБОГ, БОАЖЯ

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 08	Сар 09	Сар 10		
2	Энгийн болон аюултай хог хаягдлын гэрээ байгуулах	-	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	Гүйцэтгэх захирал	ТҮК
3	Ажиллагсдыг тоосноос хамгаалах хувцас хэрэгсэлээр хангах	-	захиалга		хүлээлцэх	Гүйцэтгэх захирал	Ажилчид
4	Байгаль орчны аудит хийлгэх	-	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	Гүйцэтгэх захирал	Мэргэжлийн байгууллага
	Нийт	-					

14 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1.	2025 оны БОМТөлөвлөгөөг танилцуулах, батлуулах	Цаасан	Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2025.05	-	Гүйцэтгэх захирал	АБОГ, БОАЖЯ
2.	2025 оны батлагдсан БОМТөлөвлөгөөг танилцуулан ажлыг эхлүүлэх	Цаасан	Ажлын жагсаалт, хугацаа, зорилтууд	2025.08	-	Гүйцэтгэх захирал	Төслийн талбай
3.	БОМТ-ны хэрэгжилтийн ажлын явцтай танилцах	Цаасан, зургаар	Байгаль орчны төлөвлөгөөнд тусгасан ажлуудын явц	2025.09	-	Гүйцэтгэх захирал	АБОГ
4.	БОМТ-ний дагуу хийгдсэн ажлыг хүлээлгэн өгөх	Цаасан, зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2025.11	-	Гүйцэтгэх захирал	АБОГ
5.	БОМТ-ны дагуу хийгдсэн ажлыг тайлагнах	Цаасан, зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг батлуулах	2025.11	-	Гүйцэтгэх захирал	АБОГ, БОАЖЯ
	Нийт				-		

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт MV-022679 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаан чулуут, Цагаан чулуут хоолойн дунд байрлах 1-12 дугаартай жалгууд дахь алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

15 БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1	Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1 497 000 төг
2	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техникийн, биологийн/	15 500 000 төг
3	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	10 000 000 төг
4	Түүх соёлын өв хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	888 000 төг
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	600 000 төг
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	Үйлдвэрлэлийн зардалд шингэсэн
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	Үйлдвэрлэлийн зардалд шингэсэн
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	355 000 төг
Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв		28 840 000 төг